

Таримал
Ургамал ХХК

ГАРЫН АВЛАГА

2026-2027

Үр тариа, тосны ургамалд зориулсан ургамал
хамгааллын бүтээгдэхүүний гарын авлага

Ургах Бүхний
URGA.MN-с

Amino BR

Цочир хүйтрэлт

Ган, хэт халалт хуурайшилтын эсрэг

Соёололтыг идэвхжүүлэх

Ургамлын өсөлтийг дэмжигч

Гэмтлийг нөхөн төлжүүлэгч

1. Үр идэвхжүүлэгч 2
- Эпи-брассинолид 0.01% 3

2. Үр ариутгал 5
- Сийдгуард - Рапс, Төмс (Тиаметоксам 280 г/л +Мефеноксам15 г/л + флудиоксанил 25г/л) 6
- Сийдгуард – Үр, тариа, төмс (Тиаметоксам 262,5 г/л Дифенконазол 25 г/л флудиоксанил 25 г/л) 8
- Тебуконазол 60г/л 10

3. Тариалалтын өмнөх болон уриншийн бодис 12
- Глифосат 540 g/l IPA 13

4. Гербицид- Хог ургамлын эсрэг 15
- Үр тарианы талбайн хог ургамлын эсрэг
  2.4-Д (2-этилгексилийн эфир), 410г/л + Флорасулам, 7.4 г/л 16
  Феноксапроп-П-этил 140г/л+антидот 35г/л 18
  Трибенурон-метил 750 г/кг 20
- Тосны тарималын хог ургамлын эсрэг
  Клопиралид 300 г/л + Пикларом 75 г/л 22
  Хизалофоп-П-Этил 125г/л 24
  Клетодим 240 г/л 26
- Эрдэншишийн хог ургамлын эсрэг
  Римсульфурон 500 г/кг 28

5. Болц түргэсгэх, хатаагч - Десикаци 30
- Дикват 20% - Мон Дикват 31

6. Инсектицид- Шавжны эсрэг ургамал хамгаалах бодис 33
- Лямбда-цигалотрин (5%) 50 г/л 34
- Лямбда-цигалотрин (10%) 100 г/кг 36
- Альфа-циперметрин 100 г/л 38
- Эсфенвалерат 50 г/л 40
- Имидаклоприд 70% 700г/кг 42
- Тиаметоксам 250 г/кг 44
- Имидаклоприд 100г/л + лямбда-цигалотрин, 50 г/л 46

7. Фунгицид 48
- Пропиконазол-300г/л+Тебуканозол-200г/л 49

8. Родентицид
- Бромодиолон (Бромодиолон 0.5%) 51

9. Гадаргуугийн идэвхжүүлэгч 52
- Трисилоксан этоксилат 53
- Этоксилат изодецилийн спирт 900г/л 55

10. Өсөлт дэмжигч, зохицуулагч био бүтээгдэхүүн, бордоо 57
- Amino BR 58
- BR24 60
- NPK 20:20:20 61
- NPK 13:7:40 62



ҮР ИДЭВХЖҮҮЛЭГЧ

УР ИДЭВХЖҮҮЛЭГЧ

Үйлчлэх бодис: Эпи-брассинолид 0.01%
Ургамлын гаралтай Био - Бүтээгдэхүүн

Эпи-брассинолид (0.01%) – Рапсын цэцгийн тоос, тооснын уутанцар, навч, иш, үндэс, цэцгийн эд эсэд ихээр агуулагддаг ургамлын өсөлтийг дэмждэг органик нэгдлээс гаргаж авсан ургамлын гаралтай **ур идэвхжүүлэгч**-өсөлт зохицуулагч юм.

Тарих үрийн соёололтыг идэвхжүүлхээс гадна, навчаар шүршиж болон бүх төрлийн усалгаагаар үндэсний системийг дэмжих зорилгоор ч хэрэглэнэ.

Ур ариутгалын бодистой хамт хэрэглэхэд таримлын хамгийн эмзэг үе буюу соёололтын хугацаанд хөрсний давсжилт, ган, хэт халалт эсвэл хүйтрэлтийг даван туулах, жигд соёолох, эрчимтэй ургах нөхцөлийг ургамлын эсийн түвшинд хүртэл үйлчилж нэмэгдүүлдэг.

Усалгаагүй тариаланд ган болон гадаад орчны стресс эсэргүүцэх чадварыг даван туулж, өсөлтийг идэвхжүүлж, нэгж га-с авах ургацын чанар болон гарцыг нэмэгдүүлдэг.

Хэрэглээ: Ур хөөх, соёолох үед үрэнд нөөцлөгддөг полисахарид, уураг, тос зэрэг усанд уусдаггүй тэжээлийн бодисыг уусах хэлбэрт задалж, ферментүүдийн идэвхжилтийг түргэсгэдэг.

Хэрэглэх заавар: Ур ариутгалын бодисын ажлын уусмалтай хамт хэрэглэхийг зөвлөдөг.



Бүх төрлийн тарималын үр	Хэрэглэх тун (л/т)	Ажлын уусмал (л/т)
Улаанбуудай	0.4	10-20
Арвай	0.4	10-20
Овьёос	0.4	10-20
Тэжээлийн ургамал	0.4	10-20
Буурцагт ургамал	0.4	10-20
Булцуут ургамал	0.4	10-20
Тосны ургамал	0.4	10-20
Модлог ургамал	0.4	10-20
Бүх төрлийн хүнсний ногооны үр	0.4	10-20

Хадгалах хугацаа, нөхцөл: 2 жил
Худалдааны нэршил: BR24



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Хэрэглэх үед үрээ хэт удаан дэвтээхээс зайлсхийх (12 цагаас дээш үед үрийн соёололт гэмтэх, хөгц мөөгөнцөр үүсэх эрсдэлтэй). Мөн дэвтээсний дараа нарны шууд тусгалаас хол сүүдэрт хатааж тавина.
2. Усны температур хэт хүйтэн байх нь бодисын үйлчлэлийг багасгана. Хэт халуун ус буюу +30°C - с дээш үед үр хөврөл гэмтэж соёолох чадваргүй болно. Иймд +18 хэмээс +25 хэмийн температур хамгийн тохиромжтой байдаг.
3. Үрийн материалыг шүлтлэг/хүчиллэг хэт өндөр бүхий химийн бодистой холихгүй. Үүнд: (KMnO4, формалин, зэсийн агууламжтай бодис)
4. Бусад төрлийн үр ариутгалын бодистой хамт хэрэглэхэд эхлээд ариутгалын бодис дараа нь BR24 бүтээгдэхүүнийг нэмэх дарааллаар ажлын уусмалыг бэлдэнэ.
5. Соёололтын хувь бага,чанарын шаардлага хангахгүй хорчгор үрэнд BR24 тус болохгүй. Иймд тарих үрийн чанарт анхаарах нь чухал.
6. Ашигласан сав баглааг Засгийн газрын 2018 оны 116 дугаао тогтоолын 1 дүгээр хавсралт-д заасны дагуу худалдагч байгууллагад буцааж тушаах үүрэгтэй.



Үр ариутгал

УР АРИУТГАГЧ

Үйлчлэх бодис: Тиаметоксам 280 г/л + Мефеноксам 15 г/л + Флудиоксонил 25 г/л

Зориулалт:
Төмс, рапс болон булцуут таримлын үр ариутгахад зориулсан өвчин болон шавжийн эсрэг системийн болон хүрэлцэх үйлчлэлтэй үр ариутгалын бодис. Үрийн материалаар дамждаг өвчин үүсгэгчид болон таримлыг ургалтын эхэн үеийн хөрс ба гадаргуу дээрх өвчин үүсгэгчид хортон шавжаас хамгаалдаг. Ургамлын өсөлт хөгжлийн физиологийн үйл ажиллагааг дэмжсэнээр таримлыг жигд соёолуулдаг. Үр ариутгалын бодисын идэвхтэй нэгдлүүд нь рапсын 9 навчтай үе шат хүртэл 25-40 хоногийн турш хөнөөлт организмаас хамгаалдаг. Ургамлын өсөлт хөгжлийн эрт үед хортон шавж, өвчний эсрэг боловсруулалт хийхгүй байх боломж олгоно.

Найрлага дахь:

Флудиоксонил (25г/л) – Хүрэлцэх үйлчлэлтэй. Аскоимицет, базидомицет зэрэг үрийн материалын хадгалалтын үеийн болон хөрсөөр дамжин халдварладаг өвчин үүсгэгчээс хамгаалдаг. Тарих үрийн гадаргууд хамгаалах давхарга үүсгэдэг. Ашиглтай бичил биетэнд сөрөг нөлөөгүй.

Мефеноксам (15г/л) – Системийн үйлчлэлтэй. Голчлон Oomycetes мөөгөнцрүүд болон үрийн хөгцний өвчин үүсгэгчээс соёололтыг хамгаална. Ургамлын үндсээр шингэж бүх хэсэгт тархдаг. Энэ нь үрийг соёолох үед шууд хамгаална.

Тиаметоксам (280г/л) – Системийн үйлчлэлтэй. Тиаметоксамын идэвхтэй нэгдэл нь ургамлын хамгийн эмзэг үе шат буюу ургалтын эхний 30 хоногийн турш үр болон ургамлыг сорох мэрэх амны эрхтэнтэй өргөн хүрээний шавьжнуудаас болон хөрсөнд амьдардаг өтнөөс хамгаална. Мөн ургамлын дархлааг сайжруулдаг онцгой үйл ажиллагаатай уургийн хэмжээ болон түүний идэвхийг нэмэгдүүлдэг үйлчилгээтэй. Жишээ нь ургамлын орчны тааламжгүй нөхцөлийг тэсвэрлэх чадвар нэмэгдүүлснээр түүний ургалт эрчимждэг нь дэлхийн олон оронд хориод төрлийн таримал дээр туршиж батлагдсан нь:

- үр тарианы ургамлын амьдралтын хувь нэмэгддэг
- ургамлын үндэсний масс нэмэгддэг
- ургацын чанар сайжирдаг

Мөн трансламинар шинж чанартай тул навчаар шүршихэд ургамалд амархан шингэж орчны таагүй нөхцөлд ч идэвхтэй байдлаа хадгалсаар байдаг.

Тарих үрийн материал	Хэрэглэх тун норм (л/т)	Ажлын уусмал (л/т)	Хөнөөлт организм
Рапс	8-16	10-50	Үндэсний илжрэл, Фомоз, Альтернариоз, Тоонолжин цэцэгтний үсрэгч цох, Рапсын навчит цох, Рапсын тасдагч, Утсан өт, Нялсуур цохны авгалдай, Шөвгөр хошуут
Төмс	0.4-0.8	7	

Аюулын зэрэг: 3 (дунд)
Хүлээх хугацаа: 40 хоног

Худалдааны нэршил: Сийдгуард- Рапс, Төмс



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Ариутгаж боловсруулсан үрийг хүнсний зориулалтаар, мал, амьтаны тэжээлд ашиглаж хэрэглэх, зарж борлуулах хориотой. Зөвхөн тарих үрийн материал ариутгах зориулалттай болно.
2. Тиометоксам-г ашиглаж байгаа үед зөгий болон ашигтай шавжинд хор нөлөө учруулж болзошгүй.
3. Зөвлөсөн тунг хэтрүүлсэн тохиолдолд үийн гадаргууг түлж, соёололтын чадварыг бууруулах эрсдэлтэй
4. Үр идэвхжүүлэгчтэй хэрэглэх тохиолдолд Үр ариутгал + Үр идэвхжүүлэгч гэсэн дарааллаар ажлын уусмал бэлдэнэ.
5. Анхны сав баглаатай 3 жил, 0 хэмээс +35 хэмд нарны шууд тусгалаас хол, хүүхэд хүрэхгүй газар хадгалж болно.
6. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах
7. Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, хувцсаа цэвэрлэх шаардлагатай.

ҮР АРИУТГАГЧ

Үйлчлэх бодис: **Тиаметоксам 265,5 г/л + Дифенконазол 25 г/л + Флудиоксонил 25 г/л**

Зориулалт:

Сийдгуард нь улаанбуудай, төмс болон булцуут таримлын үр ариутгахад зориулсан үрийн материалаар дамждаг өвчин үүсгэгчид болон таримлыг ургалтын эхэн үеийн хөрс ба гадаргуу дээрх өвчин үүсгэгчид, хортон шавжаас системийн болон хүрэлцэх үйлчлэлийн механизмаар хамгаалдаг үр ариутгалын бодис. Идэвхтэй нэгдлүүд нь 25-40 хоногийн турш хөнөөлт организмаас хамгаалдаг.

Флудиоксонил (25г/л) – Хүрэлцэх үйлчлэлтэй. Аскоимицет, базидомицет зэрэг үрийн материалын хадгалалтын үеийн болон хөрсөөр дамжин халдварладаг өвчин үүсгэгчээс хамгаалдаг. Тарих үрийн гадаргууд хамгаалах давхарга үүсгэдэг. Ашигтай бичил биетэнд сөрөг нөлөөгүй.

Дифенконазол (25г/л) – Энэ нь мөөгөнцрийн эсийн мембраны эргостерол нийлэгжилтийг дарангуйлдаг. Ингэснээр мөөгөнцрийн халдвар урган гарч буй үед урьдчилан сэргийлэх, тархалтыг зогсоох боломж олгодгоороо давуу талтай.

Тиаметоксам (265,5/л) – Системийн үйлчлэлтэй. Тариалалтын дараа үр болон таримлын соёололтыг хөрсөнд амьдрах хортон шавжаас хамгаалдаг.



Тиаметоксамын идэвхтэй нэгдэл нь ургамлын хамгийн эмзэг үе шат буюу ургалтын эхний 30 хоногийн турш үр болон ургамлыг сорох мэрэх амны эрхтэнтэй өргөн хүрээний шавжнуудаас болон хөрсөнд амьдардаг өтнөөс хамгаалхаас гадна ургамалд абиотик стрессийг даван туулах чадварыг нэмэгдүүлдэг бөгөөд энэ нь гадаад орчны таагүй нөхцөлд ч гэсэн нотлогдсон юм.

Мөн ургамлын дархлааг сайжруулдаг онцгой үйл ажиллагаатай уургийн хэмжээ болон түүний идэвхийг нэмэгдүүлдэг үйлчилгээтэй. Жишээ нь ургамлын орчны тааламжгүй нөхцөлийг тэсвэрлэх чадвар нэмэгдүүлснээр түүний ургалт эрчимждэг нь дэлхийн олон оронд хориод төрлийн таримал дээр туршиж батлагдсан нь:

- үр тарианы ургамлын амьдралтын хувь нэмэгддэг
- ургамлын үндэсний масс нэмэгддэг
- ургацын чанар сайжирдаг

Тарих үрийн материал	Хэрэглэх тун норм (л/т)	Ажлын уусмал (л/т)	Хөнөөлт организм
Улаанбуудай	1.2-1.5	10	Фузариозын үндэсний илжрэл, Хатуу харуу, цасан харуу, тоосон харуу, гельминтоспорозийн илжрэл, тоонолжин цэцэгтний үсрэгч цох,үетний ялаа, нүүгээ цохны авгалдай, колорад цох, утсан өт
Төмс	0.3-0.4	10	

Худалдааны нэршил: Сийдгуард - Үр тариа, Төмс

Хадгалах нөхцөл хугацаа: (+5С)-с + (30С), 3 жил

Саармагжих хугацаа: 40 хоног



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Тиометоксам-г ашиглаж байгаа үед зөгий болон ашигтай шавжид хор нөлөө учруулж болзошгүй.
2. Ажиллах үед хоол идэх, ус уух, тамхи татахыг хориглоно. Хүнсний зориулалттай саванд ариутгалын ажлын уусмал найруулж ашиглахыг хориглоно.
3. Ариутгаж боловсруулсан үрийг хүнсний зориулалтаар, мал, амьтаны тэжээлд ашиглаж хэрэглэх, зарж борлуулах хориотой. Зөвхөн тарих үрийн материал ариутгах зориулалттай болно.
4. Зөвлөсөн тунг хэтрүүлсэн тохиолдолд үийн гадаргууг түлж, соёололтын чадварыг бууруулах эрсдэлтэй
5. Үр идэвхжүүлэгчтэй хэрэглэх тохиолдолд Үр ариутгал + Үр идэвхжүүлэгч гэсэн дараалаар ажлын уусмал бэлдэнэ.
6. Анхны сав баглаатай 3 жил, 0 хэмээс +35 хэмд нарны шууд тусгалаас хол, хүүхэд хүрэхгүй газар хадгалж болно.
7. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах
8. Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, хувцсаа цэвэрлэх шаардлагатай.

ҮР АРИУТГАГЧ

Үйлчлэх бодис: Тебуконазол 60г/л

Зориулалт: Үр тарианы таримлын олон зүйлийн өвчний эсрэг тариалах үрийг ариутгах, үндэсний илжрэл, улаан хүрэн толбожилт, септориоз, үрийн хөгц, торон толбожилт зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлэх зориулалттай бүтээгдэхүүн.
Үрийн соёололтоос бутлалт хүртэлх хугацаанд биологийн идэвхтэй байдаг.






Тариалалт хийх тарималын үр	Төлөөлөх гол хөнөөлт организм(өвчин)	Хэрэглэх тун норм(л/тн)	Ажлын уусмал
Уриншид	Тоост харуу, фузариозын ба гельминтоспориозын үндэсний илжрэл, септориоз, үрийн хөгц	0.4-0.5	10
Арвай	Үрийн хөгц, фузариозын ба гельминтоспориозын үндэсний илжрэл	0.4-0.5	10
Хөх тариа	Фузариозын ба гельминтоспориозын үндэсний илжрэл	0.5	10
Овьёос	Тоост харуу,бүрхүүлт харуу	0.4-0.5	10
Маалинга	Антракноз	0.4-0.5	3-5

Худалдааны нэршил: ТЕБУ 60

Хадгалах нөхцөл, хугацаа: (-100С) – (+300С)хэмд 2 жил



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ!

1. Тарих үрийн материалыг тоос шороо, хогт хольцоос сайтар цэвэрлэсний дараа ашиглахыг зөвлөдөг.
2. Бодисыг хэрэглэхээс өмнө сайтар сэгсэрнэ.
3. Ажлын уусмал бэлтгэхдээ, эхлээд 1:1 харьцаагаар эх уусмал бэлдэж найруулна.
4. Ариутгагч машины савыг 1/3 хүртэл усаар дүүргээд, тасралтгүй хутгаж байх явцад бэлтгэсэн эх уусмалыг хийж өгнө.
5. Үр боловсруулах явцад үргэлжлүүлэн хутгаж байх шаардлагатай.
6. Хөрсөнд задралын хугацаа 14-30 хоног
7. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах
8. Ажлын уусмал бэлтгэхэд + 10 °C-ээс доошгүй температуртай ус хэрэглэхийг зөвлөж байна. Хэт хүйтэн ус нь бодисын уусах чадварыг бууруулж, үр нөлөөг 30 % ба түүнээс дээш хэмжээгээр багасгах эрсдэлтэй.

ТАРИАЛАЛТЫН ӨМНӨХ БОЛОН УРИНШИЙН БОДИС



УРИНШИЙН ТАЛБАЙН ГЕРБИЦИД

Үйлчлэх бодис: **Глифосат 540 г/л IPA**

Зориулалт: Уринш болон тариалангийн талбайн бүх төрлийн хог ургамлын эсрэг зориулагдсан сонгомол бус, системийн үйлчлэлтэй гербицид.

Глифосат (540 г/л) IPA – Энэ нь ургамлын амин хүчлийн нийлэгжилтийн зам болох EPSP синтезийг хориглож, улмаар навчнаас системийн үйлчлэлээр дамжин үндэс рүү хүрч хог ургамлыг үхүүлдэг, мөн ургамалын хлорофил задарч 3-7 хоногт навч шарлаж, ургамлын өсөлтыг зогсоох үйлчлэлтэй. Монгол орны цаг уурын онцлогт зориулан үндсэн түүхий эд, завсрын бодисуудын агууламжийг тусгайлан анхаарсан.

Хэрэглэх заавар:

Таримал	Хог ургамал	Тун (л/га)	Ажлын уусмал (л/га)	Хэрэглэх хугацаа
Уриншид	Нэг ба олон наст үет, Нэг ба олон наст хос үрийн талт хог ургамал	2.0-3.0	200-300	Нэг наст хог ургамлын ургалтын эхэн үед. Зарим олон наст хог ургамлын ургалтын эрчимтэй үед (мөлхөө хиаг, азарганы 10-15см өндөр ургасан үед)
Бүх төрлийн зусах таримлын тарихаас өмнө (үр тариа, төмс, буурцагтан,тэжээлий	Нэг наст үет болон хос үрийн талт хог ургамал	1.4-2.5		Тарихаас өмнө болон таримал соёолохоос өмнө, хог ургамлын ургалтын хугацаанд зуны сүүл , намар тариа хураасны дараа
	Олон наст үет хос үрийн талт хог ургамал	2.5-3.5		
ХАА-н зориулалтын бус (хамгаалалтын бүс, гудамж төмөр замын ойролцоох газар,нисэх онгоцны зурвас,үйлдвэрлэлийн нутаг дэвсгэр)	Нэг наст ба олон наст үет хог ургамал. Хос үрийн талт хог ургамал	1.4-2.8		Зохимжгүй хог ургамал устгана. (шарилж, лууль г.м) Гербицид хэрэглэсэн талбайд 15 хоногийн турш хүн байлгахыг хориглоно.
	Бүх төрлийн өвслөг хог ургамал.	2-3		
	Харьцангүй тэсвэртэй өвслөг хог ургамал	3-3.5		

Хадгалах хугацаа, нөхцөл: 3 жил

Худалдааны нэршил: Раундап

Хүлээх хугацаа: 30-40 хоног





АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ!

1. Нэг наст хог ургамлын ургалтын эхэн үе буюу 3-6 навчтай үед хэрэглэхэд тохиромжтой
2. Олон наст буюу үндэсний хэсгээр үрждэг хог ургамлын ургалтын идэвхтэй үе буюу 10- 15 см өндөртэй үед боловсруулалт хийх нь үр дүн өндөртэй. (мөлхөө хиаг, арзгар азаргана...)
3. Хавар тариалалтын өмнөх химийн боловсруулалт хийх үед агаарын температурыг онцгой анхаарах нь чухал.
4. Хавар тариалалтын өмнө цацах бол өдрийн нэмэх + хэм нь глифосат цацахад тохиромжтой буюу +15 хэмээс дээш боловч тухайн шөнийн хөрс, болон агаарын дулаан +15 хэмээс доош буухад бодисын үйлчлэл зогсох юм уу, үйлчлэл сулардаг.
6. Глифосатыг цацахаас 6 цагийн дотор бороо орох магадлалтай бол ашиглахаас зайлсхийх хэрэгтэй.
7. Салхины хурд 4м/с-с их үед цацахгүй.
8. Хавар тариалалтын өмнө цацах бол өдрийн хэм нь глифосат цацахад тохиромжтой буюу +15 хэмээс дээш боловч тухайн шөнийн хөрс, болон агаарын дулаан +15 хэмээс доош буухад бодисын үйлчлэл зогсох юм уу, үйлчлэл сулардаг.
9. Ажлын уусмал бэлтгэхэд ашиглах усны pH EC 500 µg/см-ээс дээш үед pH нь 6–7 байх ёстой. Ийм нөхцөлд усны шинжилгээ хийх шаардлагатай, мөн ус зөөлрүүлэгч бодис ашиглаж болно.
10. Метилсулфурон-метил, Трибенурон-метил, Хлорсульфурон, Флорасулам, Дикамба амин зэрэг гербицүүдтэй нийлэмжтэй.
11. Циперметрин, ламбда-цигалотрин, альфа-циперметрин, тиаметоксам, хлорпирифос зэрэг инсектицүүдтэй хосолж болно
12. Тебуконазол, пропиконазол, ципроконазол зэрэг фунгицидүүдтай нийлэмжтэй.
13. Зөвлөсөн тунгаар хэрэглэхэд хөрсний бичил организмд сөрөг нөлөөгүй.
14. Санамсаргүйгээр залгисан тохиолдолд амны хөндийг усаар зайлж, бөөлжүүлэх хэрэгтэй ба яаралтай эмчид хандах хэрэгтэй
15. Давтан хэрэглэх тохиолдолд тухайн талбайд жилд 2-3 удаа ашиглаж болно.
16. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах шаарлагатай.

Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, ашигласан



ХОГ УРГАМЛЫН ЭСРЭГ ГЕРБИЦИД

УР ТАРИАНЫ ТАЛБАЙН ӨРГӨН НАВЧИТ ХОГ УРГАМЛЫН ЭСРЭГ ГЕРБИЦИД

Үйлчлэх бодис: 2.4-Д (2-этилгексилийн эфир), 410 г/ л + флорасулам, 7.4 г/л

Зориулалт:

Энэхүү бодис нь ургамлын навчинд нэгхэн цагийн дотор нэвчиж үндэс болон ургамлын бусад хэсгүүдэд хүрч эсийн өсөлтийг хязгаарладаг. Үйлчилснээс 3-4 хоногийн дараа ургамлын навч өнгөө алдан шарлан мушгиа байдалтай болж 2-с 3 долоо хоногийн дараа хог ургамлууд бүрэн устдаг. Тариалангийн талбайн зарим төрлийн үндэсний хэсгээр үрждэг олон наст хог ургамлуудтай тэмцэхэд зориулсан системийн үйлчилгээтэй гербицид юм. Эрдэнэшиш, буудай, арвай, тритикал, хөх тариа, хошуу будааны талбайн нэг болон олон наст хос үрийн талт хог ургамлын эсрэг зааврын дагуу хэрэглэнэ. Гантай үед хэрэглэхэд ч нөлөөллөө алдалгүй үр дүнгээ хадгалдаг.

2-этилгексилийн эфир -Ауксин төст даавар шиг үйлчилж ургамлын өсөлтийг алдагдуулж үхүүлнэ. Өөрөөр хог ургамлын гормоны зохицуулалтыг эвдэх үүрэгтэй. Ургамлын флоемоор үндэс хүртэл нэвтэрдэг тул олон наст өргөн навчит хог ургамлын эсрэг өндөр үр дүнтэй.



Флорасулам- Амин хүчлийн нийлэгжилтийг зогсооно (ацетолактат синтаз) дарангуйлагч бүлэгт багтдаг системийн үйлчилгээтэй бодис. Цацсаны дараа богино хугацаанд ургамлын навч,, үндсэнд шингэж флоем болон ксилемээр дамжин өсөлтийн цэгүүдэд (меристем) хүрч үйлчилдэг. Ацетолактат синтаз ферментийг хааснаар зайлшгүй нийлэгжих ёстой амин хүчил үүсэхгүй болж, ургамлын өсөлт шууд зогсож эцэст нь үхэлд хүрнэ.

Тарих үрийн материал	Үйлчлэх хүрээ	Хэрэглэх тун/га-ын норм (л/га)	Ажлын уусмал (л/га)	Хэрэглэх хугацаа
Буудай,арвай	Нэг болон олон наст хос үрийн талт хог ургамал (Азаргана,хонгорзул, чөдөр тарна, ажигана, эгэл гаймуу, Өрөмтүүл)	0,3-0,5	100-300 литр усанд найруулна	Бутлалтаас гол хатгалтын үе шатанд шүршинэ.
Эрдэнэшиш		0,4-0,6		3-5 навчтай үед
Овъёос		0,3-0,5		Бутлалтаас гол хатгалтын үе шатанд шүршинэ.

Худалдааны нэршил: Балерина, СЭ



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Улаанбуудай, үр тарианы таримлын бутлалтын үед хэрэглэхэд тохиромжтой.
2. Эрдэнэшиш тариалалтын 3-6 навчтай үед ургалын хугацаанд 1 удаа хэрэглэх заалттай. Таримлын ургалтын үе шат алдаж цацсан тохиолдолд тарималд хор хөнөөл учруулж, ургацыг бууруулах эрсдэлтэй.
3. Бодис цацах таатай цаг агаарын температур +15oC +25oC байх нь хамгийн тохиромжтой. Агаарын хэм 25 хэмээс дээш үе болон гантай үед цацалт хийх нь бодис үр нөлөөг бууруулах эрсдэлтэй.
4. Ажлын уусмал бэлдэх усны pH 5,5-6,5 байвал тохиромжтой.
5. Шүршихээс өмнө болон дараах 4-6 цагийн хугацаанд чийг, тунадас унахгүй байх нь чухал.Хог ургамлын навч хуурай байх ёстой.
6. Бодисыг хадгалах үед сэрүүн хуурай, нарны шууд тусгалаас хол газар, хүүхэд хүрэхгүй байршилд тавих хэрэгтэй.
7. Тус бодис нь эмульс суурьтай бодис учир усанд уусамтгай адью буюу спиртэн суурьтай гадаргуугын идэвхжүүлэгч нэмж хийхийг зөвлөдөггүй.
8. 2-этилгексилийн эфир (0.28л/га) + Трибенурон-метил (15г/га) хольж ашиглаж болох ба энэ нь хос талт үрийн ургамлуудын эсрэг өргөн хүрээний үйлчлэлтэй.
9. 2-этилгексилийн эфир (0.25л/га) + Метсульфурон-метил (5г/га) хольж ашиглах боломжтой. Мөн хос үрийн талт хог ургамлыг үр дүнтэй хянах зорилготой.
10. 2-этилгексилийн эфир (0.3-0,5л/га) + Феноксапроп-П-этил (0,8-1 г/га) хольж ашиглахад нийлэмж болон үр дүн өндөр.
11. Ашигласан савыг тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй борлуулсан байгууллагад тушаах шаардлагатай.
12. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах

Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, хувцсаа цэвэрлэх шаардлагатай

ҮР ТАРИАНЫ ТАЛБАЙН ҮЕТ ХОГ УРГАМЛЫН ЭСРЭГ ГЕРБИЦИД

Үйлчлэх бодис: Феноксапроп-П-этил 140г/л+ антидот 35г/л

Зориулалт:

Үр тарианы талбайн үетэн хог ургамлын эсрэг сонгомол үйлчлэлтэй антидот агуулсан учир таримлын ургалтын үе шат үл хамааран хэрэглэнэ. Антидот нь улаанбуудайн метаболизмд эерэгээр нөлөөлж, гербицидийн сөрөг нөлөөг бууруулж таримлыг стресст орхоос хамгаалдаг. Бодисыг ашигласнаас хойш 1-3 цагийн дотор хог ургамалд нэвчин орж өсөлтийн цэгт хүрч үйлчилснээр үхүүлж эхэлдэг. Хог ургамлын хамгийн мэдрэмтгий үе шатанд (3-5навчтай үе) хэрэглэхэд өндөр үр дүнтэй.



Хэрэглэх заавар:

Шингэн бордоо, инсектицидтэй хамт үр тарианд хэрэглэхийг зөвлөдөг.

Агаарын хэм: (+10° C) - (+25° C)
Салхины хурд: 4 м/с-ээс илүүгүй байх
Хур тунадас: 6 цагийн зайтай байх


Таримал	Хог ургамал	Бодисын тун (л/га)	Ажлын уусмал (л/га)	Хэрэглэх хугацаа
Буудай	Хонгио хошуу будаа, хоног будааны зүйл, тарианы хар будаа, зэрлэг бог будаа,үнэгэн сүүл	0,3-0,6	200-300	Таримлын ургалтын бүх үе шатанд хэрэглэнэ.
Арвай Овъёос				

Хэрэглэх заавар: Бэлтгэсэн ажлын уусмалыг тухайн өдөр хэрэглэж дуусгана.

Аюулын зэрэг: 3 (дунд зэрэг)

Худалдааны нэршил: Пумасупер

Хадгалах нөхцөл, хугацаа: (+15 C) - (+25 C) 2 жил



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Хос үрийн талт буюу өргөн навчит хон ургамалд үйлчлэхгүй.
2. Үетэн хог ургамлын үе шат алдсан тохиолдолд үр дүн багатай. Нэг наст хог ургамлын 3-5 навчтай үед хамгийн өндөр үр дүнтэй.
3. Температур 10oC -с доош боолн 30oC-с дээш үед үйлчлэл удааширч мууддаг.
4. Навчны эрдэс бордоо, гуматын агууламж өндөр бордоотой хольж болохгүй, ургамлын навч түлэх, гербицидийн үйлчлэл бууруулах эрсдэлтэй.
5. Таримал ургамал хүчтэй бороо, мөндөр, ган, халуун, хортон шавж, өвчний улмаас стресст орсон үед хэрэглэж болохгүй.
6. Бодисыг цацсанаас хойш 4-6 цагийн дотор бороо орох, их хэмжээний шүүдэр буух төлөвтэй байвал бодисыг цацахыг зөвлөдөггүй.
7. Уусмалын усны pH 5-7 хатуулаг багатай байна нь чухал.
8. Салхины хурд < 4-5 м/с үед шүршилтийг хийнэ.
9. 2.4-Д (2-этилгексилийн эфир) + флорасулам-тай ашиглах боломжтой.
10. Клетодим, Хизалофоп зэрэг гербицидтэй хольж болохгүй.
11. Ашигласан сав, баглаг зааврын дагуу тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй борлуулагч байгууллагад буцаан тушаах үүрэгтэй.
12. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах
13. Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, ашигласан хувцас хэрэглэлийг зайлшгүй тусгайлан угааж цэвэрлэнэ.

ХОС ҮРИЙН ТАЛТ ХОГ УРГАМЛЫН ЭСРЭГ ГЕРБИЦИД

Үйлчлэх бодис: Трибенурон-метил 750 г/кг



Зориулалт:


Системийн үйлчлэлтэй. Үр тарианы талбайн нэг болон олон наст хос үрийн талт хог ургамлын эсрэг сонгомол үйлчилгээтэй гербицид. Хос үрийн талт хог ургамлын эсрэг өргөн хүрээний үйлчилгээ үзүүлнэ. Ацетолактот синтаз ферментийг хааж ургамлын өсөлтийг түргэн зогсоож үхэлд хүргэдэг. Навчаар шингэж -> меристемд очиж -> эсийн өсөлтийг зогсооно. Мөн 2.4Д бодисонд тэсвэртэй нэг наст өргөн навчит хог ургамлаас хамгаалдаг.

Хэрэглэх заавар:
Агаарын хэм: (+15^{0}C) - (+25^0 C)
Салхины хурд: 4 м/с-ээс илүүгүй байх
Хур тунадас: 3 цагийн зайтай байх
Хуурай сэрүүн агаар нь үйлчилгээг бууруулдаг. Трибенурон-метил 750 г/кг нь 2,4-Д болон 2М-4Х, дикамба, клопиралид гэх мэт бодисуудтай нийцдэг.

Таримал	Хог ургамал	Хэрэглэх хугацаа	Хэрэглэх норм (гр/га)	Ажлын уусмал (л/га)
Улаан буудай Арвай Овъёос	Нэг наст хос үрийн талт хог ургамал, (2,4-Д болон 2М-4Х-д тэсвэртэй)	Таримлын 2-3навчтай үе ба хог ургамлын эхэн үе	15-20	200-300
	Нэг наст хос үрийн талт хог ургамал, (2,4-Д болон 2М-4Х-д тэсвэртэй)+ Арзгар азаргана	Тариалалтын дараа хог ургамлын ургалтын эхэн үе шатанд шүршинэ. Өвөлжих үр тарианд хавар хэрэглэнэ.	20-25	
	Нэг наст хос үрийн талт хог ургамал, (2,4-Д болон 2М-4Х-д тэсвэртэй)+өрөмтүүл, шувуун тарна, арзгар азаргана, сэдэргэнэ	Тариалалтын дараа Трибенурон-метил 750 г/кг + бусад нийцэх бодис+ адью (0,2 л/га) хамт хэрэглэнэ.	10-15	

Хадгалах нөхцөл, хугацаа: -5 хэмээс- (+35) 2 жил
Аюулын зэрэг: 3 (дунд зэрэг)

Хүлээх хугацаа: 60хоног
Худалдааны нэршил: Нурон, ВДГ



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Температур 8°C-с доош үед үйлчлэх хүч сулардаг.
2. Ажлын уусмалын усны pH 6-7 байна
3. Энэхүү гербицид нь дараагийн сэлгээний болон өргөн навчит тарималд хор нөлөөгүй
4. Тухайн талбайд хог ургамлын эсрэг нэг үйлчлэгч бодистой бүтээгдэхүүнээр давтан цацалт хийх нь хог ургамал дасал болох сул талтай.
5. Трибенурон метил бодисын хог ургамалд үйлчлэх хугацаа 7-14 хоног байдаг.
6. Бодисыг цацсанаас хойш 4-6 цагийн дотор бороо орох, их хэмжээний шүүдэр буух төлөвтэй байвал бодисыг цацахыг зөвлөдөггүй.
7. Хог ургамлын тархалт болон үе шат алдсан тохиолдолд гадаргуугийн идэвхжүүлэгч болон бусад гербицид нэмж, хольж хэрэглэхийг зөвлөдөг.
8. Трибенурон-метил + 2,4Д этилгексилийн эфир + флорасулам тай хослуулж хэрэглэхэд өндөр үр дүнтэй.
9. Мөн Феноксапрап-П-этил, Флорасулам, Лямбда цигалотрин, Тебуканозол, Метсульфурон метил зэрэг бодисуудтай сайн хосолдог.
10. Шүлтлэг хөрсөнд (pH8<) үед трибенуроны задрал илүү удаан явагддаг.
11. Хизолофоп-П-Этил, клетодим зэрэг гербицидтэй нийцэхгүй.
12. Ашигласан сав, баглааг зааврын дагуу тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй борлуулагч байгууллагад буцаан тушаах үүрэгтэй.
13. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах
14. Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, ашигласан хувцас хэрэглэлийг зайлшгүй тусгайлан угааж цэвэрлэнэ.

ТОСНЫ ХОГ УРГАМЛЫН ЭСРЭГ ГЕРБИЦИД

Үйлчлэгч бодис: Клопиралид 300 г/л + л + Пикларом 75г/л

Зориулалт:

Үр тариа, рапсын тариалалтын хос үрийн талт хог ургамлын эсрэг системийн үйлчлэлээр хог ургамлыг бүрэн устгаж, дахин ургах нөхцөлийг хаах ба бодисын хамгаалалтын хугацаа урт байдаг. 2.4Д найрлагатай бодист тэсвэртэй зарим хог ургамалд сайн үйлчилдэг.(гол гэсэртэн, ноцгоно гэх мэт.) Гербицидийг цацсанаас хойш ургамлын навч, ишээр дамжин үндсэнд болон өсөлтийн цэгт тархан хүрч, хог ургамлыг үхүүлдэг. Клопиралид + Пикларом нэмснээр үе шат хэтэрсэн нэг наст хог ургамал болох лууль, өрөмтүүл зэргийг үр дүнтэй устгадаг.




Клопиралид- Ауксины төрлийн системийн үйлчилгээтэй бодис. Гербицид нь навч ба үндсээр шингэж ургамал дотор амархан тархаж үндэс ба өсөлтийн цэгт хуримтлагдана.

Таримал	Хог ургамал	Хэрэглэх тун (л/га)	Хэрэглэх тун (л/га)	Хэрэглэх норм (гр/га)	Ажлын уусмал (л/га)
Маалинга	Нэг наст хос үрийн талт	0.3-0.35	100-300	2 -4 навтай үеэс	2-4 навчтай байх үед
	Олон наст хос үрийн талт				Тэвгэн навч үүсэх үед
Рапс	Нэг наст хос үрийн талт	0.3-0.4	100-300	Рапсын 3-4 навчтай байх үед	2-4 навчтай байх үед
	Олон наст хос үрийн талт				Тэвгэн навч үүсэх үед

Аюулын зэрэг: 3 (дунд зэргийн аюултай)
Худалдааны нэршил: Галион
Хүлээх хугацаа: 30-60 хоног

Хадгалах хугацаа: 3 жилийн хугацаанд, анхны савлагаатай, -25°С-аас +25°С-ийн нөхцөлд хадгална.



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Ажлын уусмалыг бэлтгэж тухайн өдөрт нь ашиглана. Хэрэв өнжөөж ашиглавал бодисын үр дүн буурна.
2. Уусмалыг бэлтгэх, ашиглахдаа агаарын хэм +10°C-с+20°C байх үед ашиглах нь үр дүнтэй ба хэрэв +10°C-с бага үед ашиглавал бодисын үйлчлэл удааширдаг.
3. Бусад химийн бодистой урвалд орж болзошгүй тул үлдэгдэлтэй саванд бэлдэхгүй, цэвэр саванд бэлтгэнэ.
4. Бодисыг өглөө эрт эсвэл орой нар буух үед салхины хурд 4-5 м/сек байх үед ашиглах нь үр дүнтэй.
5. Ажлын уусмалын усны pH 6-7 байна
6. Бодисыг талбайд ашигласнаас хойш 3 хоногийн турш хүн байх хориотой
7. Ургамал хамгаалах бодисыг цацсанаас хойш 4-6 цагийн дотор бороо орох, их хэмжээний шүүдэр буух төлөвтэй байвал бодисыг цацахыг зөвлөхгүй
8. Уг бодис нь олон төрлийн фунгицид, инсектицидүүдтэй, мөн Этоксилат изодецилового спирта, полиэстэр трисоклан суурьтай адъюванттай нийцтэй.
9. Чихрийн манжингийн тариалалтанд Хизалофоп-П- этил, Метамитрон, Клетодим- галоксифоп-П-метил зэрэг гербицүүдтэй хосолж хэрэглэж болно.
10. Хог ургамалд тэсвэржилт үүсэхээс сэргийлэхийн тулд клопиралид бодисыг өөр химийн бүлгийн гербицидтэй ээлжлэн хэрэглэхийг зөвлөж байна
11. Бэлдмэлийг микроэлементүүдтэй (зэс, төмөр, цайр гэх мэт) холихыг хориглоно
12. Ашигласан сав, баглааг зааврын дагуу тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй борлуулагч байгууллагад буцаан тушаах үүрэгтэй.
13. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах
14. Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, ашигласан хувцас хэрэглэлийг зайлшгүй тусгайлан угааж цэвэрлэнэ.

ТОСНЫ ХОГ УРГАМЛЫН ЭСРЭГ ГЕРБИЦИД

Үйлчлэх бодис: Хизалофоп-П-Этил 125г/л

Зориулалт:

Рапс, шар лууван, шар буурцаг сонгино, манжин, төмсний талбайн нэг наст үет (хоног будаа, тарианы хар будаа, зэрлэг бог будаа) болон олон наст үет хог ургамлыг (хиаг, цагаан хялгана, жугар) системийн үйлчлэлээр бүрэн устгадаг.

Хизалофоп-П-Этил нь хог ургамлын навч, ишээр бусад эд эрхтэнүүдэд маш хурдан шингэж, үндэслэг иш болон өсөлтийн цэгт идэвхтэй хүрч, липидийн нийлэгжилтийг алдагдуулснаар ургамлыг үхэлд хүргэдэг.



Хэрэглэх заавар: Агаарын хэм: +15^0 хэмсээс +20^0
Салхины хурд: 4 м/с-ээс илүүгүй байх
Хур тунадас: 6 цагын зайтай байх

Гербицид хэрэглэснээс хойш 7-10 хоногийн дараа хог ургамлын өсөлт зогсонги байдалд орсноор гэмтлийн шинж тэмдэг ажиглагддаг. Цаг агаарын нөхцөлөөс хамаарч 2-3 долоо хоногийн дараа ургамлыг үхэлд хүргэнэ. Бараг бүх зүйлийн үет хог ургамлыг устгадаг. Таримал ургамлын хөгжлийн ямарч үе шатанд хэрэглэх боломжтой.

Таримал	Хог ургамал	Хэрэглэх тун (кг/га)	Ажлын уусмал (л/га)	Хэрэглэх хугацаа
Рапс, шар лууван, сонгино, төмс, манжин шар буурцаг	Нэг наст биелэг Хонгио хошуу будаа Хоног будааны зүйл Тарианы хар будаа Үнэгэн сүүл Мөлхөө хиаг	0.8-1.8	200-400	Таримлын ургалтын үе шатаас үл хамааран 1 наст үет хог ургамлын нэг наст хог ургамлын 2-6 навчтай үед, олон наст хог ургамлын (мөлхөө хиаг) 10-15 см өндөр үед зааврын дагуу хэрэглэнэ.

Худалдааны нэршил: Миура
Аюулын зэрэг: 3 (дунд зэрэг)

Хадгалах нөхцөл, хугацаа:(-15°C) - (+35°C),3 жил
Хүлээх хугацаа: 60 хоног



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Хос үрийн талт хог ургамлын бусад гербицидтэй хольж хэрэглэхэд зохицол сайтай.
2. Нэг наст үет хог ургамлыг 2–4 навчны үеэс бутлалтын эхлэл хүртэлх үед, олон наст хог ургамлыг 4–6 навчтай болж, 10–15 см өндөрт хүрсэн үед нь шүршинэ.
3. Хяруу, шавжнаас үүдэлтэй гэмтэл, шим тэжээлийн дутагдал зэрэг шалтгаанаар стрессэд орсон тарималд гербицид хэрэглэхийг хориглоно
4. Ажлын уусмал бэлтгэхэд ашиглагдах усны pH 5,5-6,5 байна
5. Салхи 3-4 м/с аас их үед цацахыг хориглоно.
6. Органофосфат, диметоат зэрэг шавж устгах бодистой холихыг хориглоно. (ургамал түлэх эрсдэлтэй)
7. Хизалофоп П этил бэлдмэлийг бусад пестицидтэй танкны хольцоор хэрэглэх тохиолдолд бэлдмэл бүрийн эх уусмалыг тус тусад нь саванд урьдчилан бэлтгээд, дараа нь шүршигчийн саванд нэг нэгээр нь нэмж холихыг зөвлөж байна
8. Гербицид нь зөвхөн шүршилтийн үед тарималд байгаа хог ургамлыг устгадаг. Хөрсөөр дамжихгүй бөгөөд шүршихийн дараа гарч ирсэн хог ургамалд нөлөөлөхгүй
9. Навчинд шингэдэг бусад бордоотой холихдоо болгоомжтой хандах хэрэгтэй
10. Тухайн газар хүйтрэл, гантай, бордооны түлэгдэлтэй үед цацвал үйлчлэл сулрана
11. Трибенурон-метил тэй хамт ашиглаж болох ч зарим тохиолдолд ургамалд фитотоксик шинж илрэх магадлалтай.
12. Вандуй дээр гербитокс гербицидийг хизолофоп-п этилтэй холихгүй тусад нь ашиглах шаардлагатай.
13. Стрессэд орсон таримал дээр хэрэглэхгүй
14. Шүршсэний дараа хог ургамлын өсөлт саатсан, ишний үзүүр шарласан гэх мэт анхны шинж тэмдэг 7–10 хоногийн дараа илэрдэг. Дараа нь навчны өнгөнд антоцианин (улаан-хүрэн) өнгө үүсдэг. Хог ургамлыг бүрэн устгах хугацаа нь 1–3 долоо хоног байна (хог ургамлын төрөл зүйлээс хамаарч)
15. Хур тунадасны эрсдэлгүй үед цацна.(2-3 цаг)
16. Адьювант нэмэж болно
17. Манжин дээр Десмедифам + фенмедифам, Метамитрон, Клопиралид, Метсульфурон-метил, Клопиралид пиклорам зэрэг бодистой хослуулж хэрэглэж болно.
18. Уусмалыг шүршсэний дараа 6-12 цаг тариаланд хүн/мал оруулахгүй.
19. Хаягдал сав үлдэгдлийг зааврын дагуу тусгайлан устгаж эсвэл тушаах шаардлагатай.
20. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах

Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, хувцсаа цэвэрлэх шаардлагатай

ТОСНЫ ХОГ УРГАМЛЫН ЭСРЭГ ГЕРБИЦИД

Үйлчлэгч бодис: Клетодим 240 г/л

Зориулалт:

Рапс, тосны гич, шар буурцаг, наранцэцэг тариалалтын талбайн нэг ба олон наст үет хог ургамлын эсрэг богино хугацаанд өндөр үр дүнтэй, үет хог ургамлыг сонгож устгадаг, системийн үйлчлэлтэй гербицид. Хог ургамлын навч, ишээр дамжин өсөлтийн цэгүүдэд хүрч, липид ба ацетил карбоксилазын нийлэгжилтийг хязгаарлан өсөлтийн цэгт хүрч ургалтыг зогсоож үхүүлдэг. Хог ургамалд үзүүлэх нөлөөлөл нь шүршсэнээс хойш 2-4 хоногийн дараа эхний шинж тэмдэг илрэх бөгөөд 5-7 хоногийн дотор навч цоохортонь хүрэнтэж өсөлт зогсдог.



Хэрэглэх заавар:

Таримлын нэр	Хөнөөлт организм	Бэлдмэл кг/га	Ажлын шингэн л/га
Рапс, тосны гич, шар буурцаг, хүнсний ногоо	Нэг наст үет (усан хоног, хоног будааны зүйлүүд)	0.2-0.6	200-300
	Олон наст үет (мөлхөө хийг г,м)	0.7-1.8	200-300





Худалдааны нэршил: Клетомекс
Аюулын зэрэг: 3 (дунд зэрэг)

Хадгалах нөхцөл, хугацаа:(-15°C) - (+35°C),3 жил
Хүлээх хугацаа: 60 хоног



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Давтан цацах тохиолдолд үет хог ургамалыг дасал болохоос сэргийлэхийн тулд өөр химийн бүлгийн эсвэл өөр механизмийн үйлчлэлтэй гербицидээр сольж хэрэглэхийг зөвлөж байна.
2. Хөрсний гадаргууд хамгаалалтын бүрхүүл үүсгэхгүй бөгөөд шүршилтийн дараа соёолж гарах хог ургамалд нөлөө үзүүлдэггүй.
3. Хог ургамлын ургалтын үе шатаас хамааран бодисын тунгын зааварчилгаа авах
4. Бүх төрлийн шавжны эсрэг бодистой нийлэмжтэй.
5. Хос үрийн талт хог ургамалд хэрэглэдэг MCPA, клопиралид гэх мэт гербицидтэй нийцэмжтэй.
6. Хүчиллэг өндөртэй бордоотой хольж хэрэглэхгүй
7. Клетодимийг нэг наст үет хог ургамлын 3 навчтай үеэс эхлэн хэрэглэхэд хамгийн үр дүнтэй. Олон наст үет хог ургамлын навчны талбай хангалттай томорсон (хог 10-15 см өндөр ургасан) үед гербицидийг хэрэглэхийг зөвлөдөг.
8. Бодис цацсанаас хойш, цаг агаарын тогтворгүй, таагүй нөхцөлд (хэт халалт, хяруу унах, цочир хүйтрэх гэх мэт) бодисын үйлчлэл буурч болно.
9. Гербицидийг шүршсэнээс хойш 2 цагийн дараа бороо ороход үр дүнд нөлөөлөхгүй.
10. Агаарын температур +10 хэмээс + 25 хэмд цацалт хийх нь хамгийн үр дүнтэй.
11. Ашигласан сав, баглаа зааврын дагуу тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй борлуулагч байгууллагад буцаан тушаах үүрэгтэй.
12. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах
13. Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, ашигласан хувцас хэрэглэлийг зайлшгүй тусгайлан угааж цэвэрлэнэ.

ЭРДЭНШИШИЙН ХОГ УРГАМЛЫН ЭСРЭГ

Үйлчлэх бодис: Римсульфурон 500 г/кг

Зориулалт:

Эрдэнэ шиш, улаан лоолийн талбайн нэг ба олон наст үет хог ургамал, зарим хос үрийн талт хог ургамлын эсрэг соёололтын дараа хэрэглэдэг сонгомол үйлчилгээтэй системийн гербицид. Бүх үет хог ургамлын зүйлүүд (хиаг) ихэнх хос үрийн талт хог ургамлын эсрэг өргөн хүрээнд үйлчилдэг. 5-7 хоногийн дараа гербицид цацсан хог ургамлын өсөлт хөгжилт мэдэгдэхүйц саатдаг. Сонгомол үйлчлэл нь таримлын тэжээлийн талбайг ашиглах боломжийг нэмэгдүүлж, тариалангийн талбайг хог ургамлаас чөлөөлдөг.

Хэрэглэх заавар:

Римсульфурон 500г/кг + адью 0,2 л/га гадаргуугийн идэвхүүлэгч бодистой хамт хэрэглэх нь хог ургамалд өндөр үр дүнтэй үйлчилдэг. Хөрс болон агаарын гантай нөхцөлд үет хог ургамалын эсрэг ажлын уусмалын хэмжээг 300л/га (Адью 0.3л/га) тунгаар хэрэглэнэ. Тарианы хар будаатай талбайд Римсульфурон бодисыг 25г/га-аар тооцно.

Таримал	Хог ургамал	Хэрэглэх тун (кг/га)	Ажлын уусмал (л/га)	Хэрэглэх арга хугацаа
Эрдэнэшиш	Лууль,Урвуу гагадай ,Чөдөр тарна,Шувуун тарна ,Зэрлэг манжин,Эгэл гаймуу ,Өрөмтүүл,Эмийн багваахай ,Хөдөөгийн шаралзгана,Бог будаа ,Хошуу будаа ,Тарианы хар будаа	25г +Адью 0,2	200-300	3-6 навчтай үед хэрэглэнэ
Төмс	Мөлхөө хиаг	25г +Адью 0,2	200-300	Нэг наст хог ургамал 1–4 навчтай үед, мөлхөө хиаг 10–15 см өндөр болсон үед гадаргуугийн идэвхт бодис Адью-тай хольж хэрэглэнэ.
Улаан лооль	Олон наст болон нэг наст үетэн, хос талт ургамлууд	25г +Адью 0,2	200-300	Таримал ургамал 3 навчтай үе шатанд, хог ургамал ургалтын эрт үе шатандаа байх үед Адью-тай хольж хэрэглэнэ.

Худалдааны нэршил: Эскудо ВДГ
Аюулын зэрэг: 3 (дунд зэрэг)

Хүлээх хугацаа: 20-30 хоног
Хадгалах хугацаа, нөхцөл:(-30°C) - (+30°C)-т 3 жил



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Шүршилт хийх хамгийн тохиромжтой температур нь + 15– + 25°C байна. Шүршилтийн өмнө болон дараа агаарын температур +10°C-ээс доош буурах, эсвэл 25°C-ээс дээш гарах төлөвтэй байвал хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй.
2. Ажлын уусмалын усны pH 6-7 байх
3. Нэг наст хог ургамал ургалтын эхний үе шатандаа римсульфуронд мэдрэмтгий байдаг.
4. Үет хог ургамлын 3 навчтай байх үед, хос үрийн талт хог ургамалд жинхэнэ 2- 4 навчтай үед римсульфуроны хэрэглэх норм 25г/га байна
5. Фитотоксик нөлөө үүсэх эрсдэлтэй тул уг бэлдмэлийг органофосфорын бүлгийн инсектицидүүдтэй хамт хэрэглэхийг зөвлөхгүй. Мөн эдгээр бэлдмэлтэй ээлжлэн хэрэглэх тохиолдолд шүршилтүүдийн хооронд дор хаяж 14 хоногийн зайтай байх ёстой.
6. Зөвлөсөн тун, нормын дагуу хэрэглэсэн тохиолдолд уг бэлдмэл нь таримал ургамалд фитотоксик нөлөө үзүүлэхгүй
7. Адьювант эсвэл бусад төрлийн гадаргуугын идэвхжүүлэгч нэмж ашиглахыг зөвлөдөг
8. Эрдэншишийн тариалалтанд 2,4 д-этилгексийн эфир (0.3л/га) хольж ашиглаж болно.
9. Сульфонилмочевины бүлгийн гербицидийг удаан хугацаанд, давтан хэрэглэх нь зарим төрлийн хог ургамалд тэсвэржилт үүсэхэд хүргэж болзошгүй. Үүнээс сэргийлэхийн тулд үйлчлэлийн механизм нь өөр өөр химийн бүлгийн гербицидүүдийг ээлжлэн хэрэглэх, эсвэл хосолсон найрлагатай бэлдмэл ашиглахыг зөвлөж байна.
10. Бодиыг анхны савлагаатайгаар пестицид хадгалахад зориулан тусдаа агуулахад 0-аас +30 °C хүртэлх температурын нөхцөлд хадгална.
11. Салхины хурд 4м/с-ээс ихгүй байх
12. Хур тунадас 6 цагийн зайтай байх
13. Ашигласан сав, баглааг зааврын дагуу тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй борлуулагч байгууллагад буцаан тушаах үүрэгтэй.
14. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах
15. Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, ашигласан хувцас хэрэглэлийг зайлшгүй тусгайлан угааж цэвэрлэнэ.



Болц түргэсгэх, хатаагч ДЕСИКАЦИ

БОЛЦ ЖИГДРҮҮЛЭГЧ, ХАТААГЧ

Үйлчлэгч бодис: Дикват 200г/л



Зориулалт:

Таримлын болцыг богино хугацаанд түргэсгэх хүрэлцэх үйлчлэл бүхий хатаагч бодис.

- Ургамлын болцыг жигдрүүлж, үрэн дэх чийгийг богино хугацаанд багасгаж хатаана.

20-30 минутын дотор үйлчлэл нь явагдаж үр нөлөө нь 1 өдрийн дараа ажиглагдана.

- Идэвхтэй бодис нь ургамалд үйлчлэн хурдан задардаг тул үр тариа, түүний бүтээгдэхүүний хүнсний аюулгүй байдалд сөрөг нөлөөгүй олон улсад хүлээн зөвшөөрсөн.
- Хог ургамлын иш навчийг хатааж хураалтыг хөнгөвчилнө.

Хэрэглэх заавар:

Агаарын хэм: (+10°C) + (25°C)
Салхины хурд: 4 м/с-ээс илүүгүй байх
Хур тунадас: 2 цагын зайтай байх

Таримлын нэр	Хэрэглэх норм(л/га)	Ажлын уусмал (л/га)	Хэрэглэх хугацаа
Улаанбуудай Арвай Овъёос	2- 3	200-450	Хураалтаас 5-7 хоногийн өмнө үрийн чийг 30 % ихгүй үед
Рапс	1.5 - 3	200-450	Дунд эгнээний хонхорцогийн 70% хүрэнтэхэд
Вандуй	2.0-3	200-400	Үрийн чийн 45%-иас ихгүй үед
Уринш	3.5-4	200-400	Хог ургамлын идэвхтэй ургалтын үед

Худалдааны нэршил: Реглон
Аюулын зэрэг: 3 (дунд зэрэг)

Хадгалах нөхцөл, хугацаа: (00С) - (+300С)-т 2 жил
Хүлээх хугацаа: 7-10 хоног



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Болцын зөв үе шатанд цацах:
Цэцэглэлтийн үе шат бүрэн дууссан байх, рапсын болцын төгсгөл үе шат буюу голын эгнээний хонхорцгийн үрийн өнгө 70% хүртэл хүрэнтсэн байх ёстой.
2. Улаанбуудайн аарцан болцын төгсгөл үе шатанд, үрийн чийн 30%-иас ихгүй үе, хураалтаас 5-7 хоногийн өмнө цацна.
3. Ажлын уусмалын усны pH 5,0-6,5 байх нь тохиромжтой (саармаг бага зэрэг хүчиллэг орчинд дикват илүү тогтвортой, үйлчлэл жигд байдаг гэж үздэг) pH 7-оос дээш шүлтлэг усанд үйлчлэл сулрах юм уу идэвх буурах эрсдэлтэй
4. Таримлын болцын жигд үед десикаци хийх ёстойг анхаарна уу.
5. Үрийн чийгийг багасгах бус ногоон массыг хагдруулах зорилгоор цацах тохиолдолд бодисын тун,норм болон ажлын уусмалын зарцуулалтын хэмжээ өөрчлөгдөхийг анхаарна уу. (технологийн зааварчилгаа мэргэжлийн агрономчоос авах)
6. Намар хэрэглэхэд өдрийн хэм нь Дикват цацхад тохиромжтой буюу +25^{0} хэмээс дээш боловч тухайн шөнийн хөрс болон агаарын дулаан +15^{0} хэмээс доош буухад бодисын үйлчлэл зогсох юм уу сулардаг.
7. Хаягдал сав үлдэгдлийг зааврын дагуу тусгайлан устгаж эсвэл тушаах шаардлагатай.
8. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах
9. Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, хувцсаа цэвэрлэх шаардлагатай



ИНСЕКТИЦИД- ШАВЖНЫ ЭСРЭГ УРГАМАЛ ХАМГААЛАХ БОДИС

ХОРТОН ШАВЖНЫ ЭСРЭГ ИНСЕКТИЦИД

Үйлчлэх бодис: Лямбда-цигалотрин 50г/л
Аюулын зэрэг: Бага хортой



Зориулалт:
Ойн ба бэлчээрийн хортон болон үр тариа, хүнсний ногоо, жимс жимсгэний хортон, агуулахын хөнөөлт шавж, хачигтай тэмцэхэд зориулсан. Хортон шавжид хүрэлцэх болон хоол боловсруулах эрхтний замаар үйлчилнэ. Хортон шавжны гадна хальсан давхаргад нэвтэрч мэдрэлийн тогтолцоонд нөлөөлдөг.
- Олон төрлийн таримал дээр өргөн хүрээний хортонд үйлчилдэг.
- Шавжаас гадна мөн хачиганд үйлчилдэг.
- Ургамалд хуримтлагддаггүй, байгаль орчинд үзүүлэх хор нөлөө бага.
- Богино хугацаанд "нок-даун" үйлчилдэг.
- Үргээж дайжуулах үйлчилгээтэй.

Хэрэглэх заавар:

Таримал	Шавж	Хэрэглэх тун (л/га)	Ажлын уусмал (л/га)	Хэрэглэх хугацаа
Улаанбуудай	Буудайн цацаг далавчтан (трипс), гессен ялаа, цох,бөөс, царцаа нугын бор эрвээхэй, хивэн эрвээхэй	0.1-0.2	200-400	Дайжуулах зорилгоор болон Ургалтын бүх үе шатанд
Арвай	Маврын бясаа, тарианы бүгэг	0.15-0.2	200-400	Дайжуулах зорилгоор болон Ургалтын бүх үе шатанд
Рапс	Рапсын цэцэг идэгч цох, рапсын хярга,	0.1-0.15	200-400	Ургалтын бүх үе шатанд
Бэлчээр	Царцаа, нугын бор эрвээхий	0.2-0.3	200-400	Шавж ихээр үзэгдэх үед, мөн дайжуулах зорилгоор

Худалдааны нэршил: Каратэ МКС

Хадгалах нөхцөл,хугацаа: (-5°C) – (+35°C) 3 жил
Хүлээх хугацаа: 25 хоног



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Агаарын хэм: (10°C) - (+30°C) үед ашиглах нь үр дүнтэй
2. Салхины хурд: 4 м/с-ээс илүүгүй байх
3. Ажлын уусмалын усны pH 5-7 байх
4. Хур тунадас: 3 цагийн зайтай байх
5. Ихэнх пестицидтэй нийцдэг. Ажлын уусмалд Аллюр эсвэл Полифем зэрэг адъювант нэмж болно
6. Хүчтэй шүлтлэг эсвэл хүчтэй хүчиллэг урвалтай пестицидүүдтэй хамт ашиглахыг хориглоно
7. Уусмалыг хадгалахдаа хүйтэн газар хөлдөөж болохгүй
8. Хаягдал сав үлдэгдлийг зааврын дагуу тусгайлан устгаж эсвэл тушаах шаардлагатай.
9. Ашиглаж байх үед мал, тэжээвэр амьтдыг ойртуулж болохгүй
10. Лямбда-цигалотрин нь загас, усны сээр нуруугүйтэд хоруу чанартай тул усны эх үүсвэр руу оруулахыг хориглоно
11. Нүд арьс салстад хүрсэн бол усаар 10-15 мин угаах, шаардлагатай тохиолдолд эмчид яаралтай хандах шаардлагатай
12. Уусмалыг бэлдэж байх хугацаанд тамхи татах, ил гал гаргахыг хориглоно
13. Бүтээгдэхүүнийг хэрэглэх үед хамгаалалтын хувцас, амны хаалт (N95), хамгаалалтын бээлий ашиглах
14. Ашигласан сав, баглаа зааврын дагуу тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй борлуулагч байгууллагад буцаан тушаах үүрэгтэй.

ХОРТОН ШАВЖНЫ ЭСРЭГ ИНСЕКТИЦИД

Үйлчлэх бодис: Лямбда-цигалотрин 100г хуурай
Аюулын зэрэг: Хортой



Зориулалт:

Бэлчээр, ойн хортон болон үр тариа, хүнсний ногоо, жимс жимсгэний хортон, агуулахын хөнөөлт шавж, хачигтай тэмцэхэд зориулсан. Хортон шавжид хүрэлцэх болон хоол боловсруулах эрхтний замаар үйлчилнэ. Хортон шавжны гадна хальсан давхаргад нэвтэрч мэдрэлийн тогтолцоонд нөлөөлдөг.

- Олон төрлийн таримал дээр өргөн хүрээний хортонд үйлчилдэг.
- Шавжаас гадна мөн хачиганд үйлчилдэг.
- Ургамалд хуримтлагддаггүй, байгаль орчинд үзүүлэх хор нөлөө бага.
- Богино хугацаанд "нок-даун" үйлчилдэг.
- Үргээж дайжуулах үйлчилгээтэй.

Хэрэглэх заавар:

Таримал	Шавж	Хэрэглэх тун (кг/га)	Ажлын уусмал (л/га)	Хэрэглэх хугацаа
Улаанбуудай	Буудайн цацаг далавчтан (трипс), гессен ялаа, цох,бөөс, царцаа нугын бор эрвээхэй, хивэн эрвээхэй	80г-100г	200	Дайжуулах зорилгоор болон Ургалтын бүх үе шатанд
Арвай	Маврын бясаа, тарианы бүгэг, хивэн эрвээхэй	80г-100г	200	Дайжуулах зорилгоор болон Ургалтын бүх үе шатанд
Рапс	Рапсын цэцэг идэгч цох, рапсын хярга,	80г-100г	200	Ургалтын бүх үе шатанд
Бэлчээр	Царцаа, нугын бор эрвээхий	80г-100г	200	Шавж ихээр үзэгдэх үед, мөн дайжуулах зорилгоор

Худалдааны нэршил: Икон 10%

Хадгалах нөхцөл,хугацаа: (-5°C) – (+35°C) 5 жил
Хүлээх хугацаа: 25 хоног



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Агаарын хэм: (10°C) - (+30° C) үед ашиглах нь үр дүнтэй
2. Салхины хурд: 4 м/с-ээс илүүгүй байх
3. Ажлын уусмалын усны pH 5-7 байх
4. Царцаа устгалын ажилд ашиглах бол бодис цацсан талбайд хамгийн багадаа 30 хоног хүн ойртохгүй байх. Тухайн бодис цацсан газраас мөөг жимс түүх болон тарих хориотой
5. СП хэлбэр нь шингэнээс илүү амьсгалын замаар хордлого үүсгэх боломж ихтэй учир усанд найруулахдаа тоос үүсгэхгүйгээр аажмаар уусгах шаардлагатай
6. Лямбда-цигалотрин нь загас, усны сээр нуруугүйтэд хоруу чанартай тул усны эх үүсвэр руу оруулахыг хориглоно
7. Уусмалыг хадгалахдаа хүйтэн газар хөлдөөж болохгүй, мөн хүүхэд хүрэхээргүй газар хадгалах,
8. Тэсвэржилт үүсэхээс сэргийлэхийн тулд энэхүү бэлдмэлийг өөр үйлчлэлийн механизмтай инсектицидүүдтэй ээлжлэн хэрэглэхийг зөвлөж байна.
9. Хаягдал сав үлдэгдлийг зааврын дагуу тусгайлан устгаж эсвэл тушаах шаардлагатай.
10. Ашиглаж байх үед мал, тэжээвэр амьтдыг ойртуулж болохгүй
11. Хур тунадас: 3 цагийн зайтай байх
12. Бодисын улмаас толгой өвдөх, дотор муухайрах, арьс загатнах шинж тэмдэг илэрвэл ажиллагааг зогсоож цэвэр агаарт гарах, нүд арьсанд хүрсэн бол усаар удаан хугацаагаар угаах ёстойг анхаарна уу
13. Уусмалыг бэлдэж байх хугацаанд тамхи татах, юм идэж уухыг хориглоно
14. Амьсгалын шүүлтүүртэй маск (P2/P3) ашиглах

Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, хувцсаа цэвэрлэх шаардлагатай

ХОРТОН ШАВЖНЫ ЭСРЭГ ИНСЕКТИЦИД

Үйлчлэх бодис: Альфа-циперметрин 100 г/л
Аюулын зэрэг: Хортой



Зориулалт:

Буудай, үр тариа, рапс, чихрийн манжин ба бусад хөдөө аж ахуйн тарималд хөнөөл учруулдаг хортон шавжтай(бөөс, цикад, хивэн эрвээхэй) тэмцэхэд хэрэглэх шавжны эсрэг бэлдмэл. Энэ нь шавжийн төв мэдрэлийн системийг гэмтээж эсийн мембраны нэвтрүүлэх чадварыг алдагдуулж, натрийн сувгийг хааж, шавжийг хурдан үхэлд хүргэнэ. Мөн тариалангийн талбайн хөнөөлт организмийн эсрэг урьдчилан сэргийлэх, дайжуулах үйлчлэлтэй.

Хэрэглэх заавар:

Таримлын ургалтын хугацаанд:

Таримал	Хөнөөлт шавж	Хэрэглэх тун (л/га)	Ажлын уусмал (л/га)
Буудай, арвай	Ялаа	0.1-0.15	100-200
	Нөмрөгт бясаа		
	Бүүрэг, бөөс, трипс, цикад	0.1	200-400
Рапс, гич (тэжээлийн ба тосны гич)	Рапсын цэцэг идэгч, цэцгийн бөөс, рапсын хярга, үсрэгч цох, тоонолжтоны бясаа	0.1-0.15	200-400
Чихрийн болон тэжээлийн манжин	Навчны ширх ,ялаа, ургамлын бөөс	0.1	100-300
Эрдэнэшиш Вандуй	Цикад Үрч цох	0.15-0.2	200-400

Худалдааны нэршил : Фаскорд КЭ

Хүлээх хугацаа: 20 хоног



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Ажлын уусмалыг хэрэглэхийн өмнө бэлтгэх ба бэлдсэн өдрөө хэрэглэнэ. Шүршигчийн уусмал найруулах савны ½ -д ус хийгээд бэлдмэлийг бүтэн тунгаар хийж дээрээс нь усыг шаардлагатай хэмжээнд нь хүртэл нэмнэ. Дараа нь сайтар хутгаж холино. Шүршилтийг салхигүй үед өглөө, оройн цагаар ургамлын навчны гадаргуу дээр жигд тараах байдлаар шүршиж гүйцэтгэнэ.
2. Бэлдсэн уусмалыг 2 цагийн дотор хэрэглэнэ
3. Усны pH 5-7 хооронд байх
4. Хэрэглэх зааврыг ягштал мөрдсөн тохиолдолд бэлдмэл нь таримал ургамалд фитотоксик нөлөөгүй.
5. Зааврын дагуу хэрэглэвэл тэсвэржилт үүсэх магадлал бага. Гэсэн хэдий ч үүнээс сэргийлэхийн тулд уг бэлдмэлийг өөр үйлчлэлийн механизмтай инсектицидүүдтэй ээлжлэн хэрэглэхийг зөвлөж байна.
6. Бэлдмэл нь хүчтэй шүлтлэг эсвэл хүчтэй хүчиллэг урвалтай бэлдмэлээс бусад олон төрлийн пестицидтэй нийцтэй
7. Альфа-циперметрин нь хүн болон хөхтөн амьтдад өндөр хортой нэгдэл бөгөөд ашиглах үед аюулгүй ажиллагааны арга хэмжээ болон хэрэглээний дүрмийг чанд мөрдөх шаардлагатай
8. Альфа-циперметринээр хордох үед хөдөлгөөн алдагдах, таталт өгөх, чичрэх, шүлс гоожих, нулимс ихсэх зэрэг шинж тэмдгүүд илэрнэ
9. Зөгийнд хоруу чанар өндөр учир анхаарна уу
10. 3 жил, бэлдмэлийг хуурай нөхцөлд -150С – +300 С зориулалтын байр саванд хадгална.
11. Бодисын улмаас толгой өвдөх, дотор муухайрах, арьс загатнах шинж тэмдэг илэрвэл ажиллагааг зогсоож цэвэр агаарт гарах, нүд арьсанд хүрсэн бол усаар удаан хугацаагаар угаах ёстойг анхаарна уу
12. Уусмалыг бэлдэж байх хугацаанд тамхи татах, юм идэж уухыг хориглоно

Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, хувцсаа цэвэрлэх шаардлагатай

РАПСЫН ХОРТОН ШАВЖНЫ ЭСРЭГ ИНСЕКТИЦИД

Үйлчлэх бодис: Эсфенвалерат 50г/л
Аюулын зэрэг: Бага хортой



Зориулалт:
Мэрэх болон сорох амны эрхтэнтэй хортон шавжуудад хүрэлцэх болон хоол боловсруулах замаар богино хугацаанд дайжуулах, хордуулах, үхүүлэх үйлчилгээтэй. Ялангуяа хайрсан далавчтанд хөгжлийн аль ч үе шатанд гойд сайн үйлчилдэг. Эсфенвалерат нь нийлэг пиретроидын ангилалд хамаарна. Бэлдмэл нь хортон шавжид хүрэлцэх болон гэдэсний давхар үйлчлэлтэй. Шавжийн мэдрэлийн системд нөлөөлж, саажилт үүсгэн богино хугацаанд үхэлд хүргэнэ. Мөн шавжийг үргээх болон хооллолтыг дарангуйлах өндөр нөлөөтэй.

- Хортон шавжийг богино хугацаанд үхүүлдэг.
- Давхар дайжуулан үргээх үйлчилгээтэй.
- Нас бие гүйцсэн шавж, өт, авгалдайд адил үйлчилдэг.

Хэрэглэх заавар:

Таримал	Хөнөөлт шавж	Хэрэглэх тун(л/га)	Ажлын уусмал (л/га)	Хэрэглэх хугацаа
Рапс	Цагаан эрвээхий, бүгэг эрвээхий , хивэн эрвээхий	0.3	200-400	30 хоногт 1 удаа
Маалинга	Маалингийн цох	0.2-0.3	100-200	

Худалдааны нэршил: Сэмпай КЭ

Хадгалах нөхцөл, хугацаа: (-15°C-аас +35°C) 3 жил
Хүлээх хугацаа: 30 хоног



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Ажлын уусмалын усны pH 5-6.5 хооронд байх
2. Ажлын уусмалд ургамлын навчин дээр жигд тархуулахын тулд Адью болон гадаргуугийн идэвхжүүлэгч нэмж хийхийг зөвлөдөг.
3. Шүршигчийн савыг ойролцоогоор хүртэл цэвэр усаар дүүргээд хутгагчийг асаана. Дараа нь нэг шүршигчид тохируулан тооцсон хэмжээгээр бэлдмэлийг нэмж, уусмалыг жигд болтол хутгангаа савыг дүүртэл усаар нэмнэ. Шүршилтийн туршид хутгалтыг тасралтгүй үргэлжлүүлнэ.
4. Бэлтгэсэн ажлын уусмалыг тухайн өдөрт нь бүрэн ашиглах ёстой.
5. Зөвлөмжийн дагуу хэрэглэсэн тохиолдолд таримал ургамалд фитотоксик нөлөө үзүүлэхгүй
6. Бодис нь хөрсний организмууд болон шувуунд хор хөнөөл багатай боловч зөгийнд хоруу чанар өндөр.
7. Навчны гадаргууд тогтдог, ургамалд шингэхгүй тул бэлдмэлийг хур тунадас унаагүй үед, хурц наргүй өдөр өглөө оройн тогтуун цагаар ургамалд шүршилт хийх аргаар, хортны тоо толгой хэт олширсон тохиолдолд хэрэглэнэ.
8. Дасжилт үүсэхээс сэргийлэхийн тулд энэхүү бэлдмэлийг үйлчлэлийн механизм нь өөр төрлийн шавж устгах бодистой ээлжилж хэрэглэхийг зөвлөдөг
9. Энэ бэлдмэл нь маш хүчтэй шүлтлэг эсвэл хүчтэй хүчиллэг урвалтай бэлдмлүүдээс бусад төрөл бүрийн пестицидтэй нийлэмжтэй.
10. Бодисыг пестицид хадгалах зориулалтын тусгай агуулахад, агаар нэвтрэхгүй битүү, гэмтээгүй үйлдвэрийн анхны савлагаатайгаар хадгална.
11. Бодисоор хордосны улмаас толгой өвдөх, дотор муухайрах, арьс загатнах шинж тэмдэг илэрвэл ажиллагааг зогсоож цэвэр агаарт гарах, нүд арьсанд хүрсэн бол усаар удаан хугацаагаар угаах ёстойг анхаарна уу
12. Ашигласан сав, баглааг зааврын дагуу тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй борлуулагч байгууллагад буцаан тушаах үүрэгтэй.
13. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах
14. Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, ашигласан хувцас хэрэглэлийг зайлшгүй тусгайлан угааж цэвэрлэнэ.

ХОРТОН ШАВЖНЫ ЭСРЭГ ИНСЕКТИЦИД

Үйлчлэх бодис: Имидаклоприд 70% 700г/кг
Аюулын зэрэг: Бага хортой



Зориулалт:
Таримлын төрөл бүрийн хортон шавжтай тэмцэхэд зориулсан системийн үйлчилгээтэй инсектицид. Ургамлын бөөс, трипс, цагаан далавчтан зэрэг шавжаас гадна навч идэгч бүх төрлийн шавжид өргөн хүрээтэй үйлчилдэг. Навчинд шүршилт хийх, ургамлын орчим хөрсөнд хийх зэргээр хэрэглэнэ. Нематод болон аалзан хачигт үйлчлэхгүй ч морин шоргоолжинд сайн үйлчилнэ.
Шавжийн төв мэдрэлийн системд үйлчилдэг, хөхтөн амьтдад бага хоруу чанартай байдаг.

Хэрэглэх заавар:
Агаарын хэм: (+12°C) - (+25°C)
Салхины хурд: 4 м/с-ээс илүүгүй байх
Хур тунадас: 3-4 цагийн зайтай байх

Таримал	Хөнөөлт шавж	Бэлдмэлийн тун (кг/га)	Ажлын уусмал (л/га)	Хэрэглэх давтамж
Улаанбуудай	Үр тарианы бөөс, трипс,цохнууд	0.03-0.05	200-400	Бутлалтаас түрүүлэлтийн эхэн шатанд шүршилт хийнэ.
Овъёос		0.03	200-400	Ургалтын үед шавж илэрсэн үед
Арвай		0.03	200-400	Ургалтын үед шавж илэрсэн үед
Рапс		0.03	200-400	

Худалдааны нэршил: Конфидор экстра

Хадгалах нөхцөл, хугацаа: -10°C -ээс +10°C-т 3 жил
Хүлээх хугацаа: 25 хоног



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Имидаклоприд нь thiamethoxam шиг голчлон навчинд судасны системээр нэвтэрч, үр, жимсэнд нэвчиж ордоггүй болох нь тогтоогдсон бөгөөд үүгээрээ давуу талтай.
2. Улаанбуудайн трипс, үр тарианы бөөс, гессейн ялаа их тархсан, хөнөөлийн босго давсан үед хамгийн өндөр үр дүнтэй тэмцдэг инсектицид.
3. Бодисын улмаас толгой өвдөх, дотор муухайрах, арьс загатнах шинж тэмдэг илэрвэл ажиллагааг зогсоож цэвэр агаарт гарах, нүд арьсанд хүрсэн бол усаар удаан хугацаагаар угаах ёстойг анхаарна уу
4. Ашигласан сав, баглааг зааврын дагуу тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй борлуулагч байгууллагад буцаан тушаах үүрэгтэй.
5. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах
6. Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, ашигласан хувцас хэрэглэлийг зайлшгүй тусгайлан угааж цэвэрлэнэ.

ХОРТОН ШАВЖНЫ ЭСРЭГ- ИНСЕКТИЦИД

Үйлчлэх бодис: Тиаметоксам 250 г/кг
Аюулын зэрэг: Бага хортой

Зориулалт:

Тиаметоксамыг таримлын ургалтын үед навчаар шүрших болон хөрсөнд цацах нь олон зүйлийн хортоны эсрэг тэмцэхэд зориулсан өндөр үр дүнтэй неоникотиноидын бүлгийн ганц инсектицид.

Тиаметоксам нь ургамлын дархлааг сайжруулдаг онцгой үйл ажиллагаатай уургийн хэмжээ болон түүний идэвхийг нэмэгдүүлдэг үйлчилгээтэй. Жишээ нь, ургамлын орчны тааламжгүй нөхцөлийг тэсвэрлэх чадвар нэмэгдүүлснээр түүний ургалт эрчимждэг нь дэлхийн олон оронд 20-иод төрлийн таримал дээр туршиж батлагдсан нь:

- Үр тарианы ургамлын амьдралтын хувь нэмэгддэг
- Ургамлын үндэсний масс нэмэгддэг
- Ургацын чанар сайжирдаг

Үйлчлэх хүрээ:

Сорох амны эрхтэнтэй (бөөс,цагаан далавчтан, цикад), мэрэх амны эрхтэнтэй (колорад цох,шөвгөр хошуут, навч хөндийлөгч, трипсийн зүйлүүд, царцаа,бясаа), бусад (утсан өт, таслагч)

Тиаметоксам нь системийн үйлчилгээтэй тул хөрсөнд цацахад ургамлын үндэсний системээр дамжин богино хугацаанд ургамлын эд эсээр тархан ургамлын газрын доод болон дээд хэсэгт хүрч хамгаалдаг.

Мөн трансламинар шинж чанартай тул навчаар шүршихэд ургамалд амархан шингэж орчны таагүй нөхцөлд ч идэвхтэй байдлаа хадгалсаар байдаг.

Хэрэглэх заавар:

Агаарын хэм: (+10) - (+29)
Салхины хурд: 4 м/с-ээс илүүгүй байх
Хур тунадас: 3 цагын зайтай байх

Тариалалт хийх таримлын үр	Төлөөлөх гол хортон шавьж	Хэрэглэх тун норм (кг/тн)	Ажлын уусмал (л/га)	Хамгаалах хугацаа (хоног)
Улаанбуудай	Тарианы бүүргэнэ, бамбайт бясаа, хөрсний авгалдай	0.06-0.08	200-400	30
Овъёос	Тарианы бүүргэнэ, үр тарианы цох,хөрсний авгалдай	0.06-0.08	200-400	28
Вандуй	Үрч цох, бөөс,	0.1	200-400	15
Төмс (тариалалт хийсэн хөрсөнд цацах)	Утсан өт, хөрсөнд амьдрах чадвартай хортон	0.4-0.6	75-150	30-60
Төмс (ургалтын үед)	колорад цох гарсан үед	0.08	200-400	14
Сонгино	Сонгины ялаа,түүний өт	0.3-0.6	200-400	14-28

Худалдааны нэршил: Актара ВДГ

Хадгалах нөхцөл, хугацаа: (-10°C) +(35°C)-т 4 жил
Хугацаа: 14-40 хоног



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Бодисыг ойролцоогоор +20°C-ын усанд уусган ажлын уусмал бэлтгэнэ.
2. Лямбда-цигалотрин+тиаметоксам хамт ашиглаж болно
3. Тиаметоксам+мефеноксам+ флудиоксонил хамт нийлэмжтэй
4. Бодисын улмаас толгой өвдөх, дотор муухайрах, арьс загатнах шинж тэмдэг илэрвэл ажиллагааг зогсоож цэвэр агаарт гарах, нүд арьсанд хүрсэн бол усаар удаан хугацаагаар угаах ёстойг анхаарна уу
5. Уусмалыг бэлдэж байх хугацаанд тамхи татах, юм идэж уухыг хориглоно
6. Хаягдал сав үлдэгдлийг зааврын дагуу тусгайлан устгаж эсвэл тушаах шаардлагатай.
7. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах

Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, хувцсаа цэвэрлэх шаардлагатай

ХОРТОН ШАВЖНЫ ЭСРЭГ ИНСЕКТИЦИД

Үйлчлэх бодис: Имидаклоприд 150г/л + лямбда-цигалотрин, 50 г/л

Аюулын зэрэг: Бага хортой

Зориулалт:

Имидаклоприд нь неоникотиноид (хлороникотинил) ангилалд хамаарах, системийн үйлдэлтэй, олон төрлийн мэрэх, сорох амны эрхтэнтэй хортон шавжийн хүрэлцэх болон хоол боловсруулах эрхтний замаар үйлчилдэг.

Лямбда-цигалотрин нь синтетик пиретроид бөгөөд контакт болон гэдэсний үйлдэл үзүүлдэг, мөн ургамал иддэг хачигт ч үр дүнтэй байдаг. Лямбда-цигалотрин контакт үйлдэлтэй, оксидатив фосфорчлалыг дарангуйлагч инсектицид бөгөөд шүршигдсэн ургамлын гадаргуу дээр хадгалагддаг. Нарны гэрэл, халуунд тэсвэртэй, тогтвортой нөлөөтэй



Хэрэглэх заавар:

Агаарын хэм: (+10) - (+30)
Салхины хурд: 4 м/с-ээс илүүгүй байх
Хур тунадас: 3 цагын зайтай байх

Таримал	Шавж	Хэрэглэх тун (кг/тн)	Ажлын уусмал (л/га)	Хэрэглэх хугацаа
Улаанбуудай	Буудайн цацаг далавчтан (трипс), гессен ялаа, цох,бөөс, царцаа, нугын бор эрвээхэй, судалт нөмрөг	0.08-0.15	200-400	Дайжуулах зорилгоор болон Ургалтын бүр үе шатанд
Арвай	Маврын бясаа,тарианы бүгэг	0.08-0.15	200-400	Дайжуулах зорилгоор болон Ургалтын бүр үе шатанд
Рапс	Рапсын цэцэг идэгч цох, рапсын хярга,	0.08-0.15	200-400	Ургалтын бүх үе шатанд
Бэлчээр	Царцаа Хос далавчтан Хайрсан далавчтан	0.1-0.15	300-400	Шавьж ихээр тархсан үед

Худалдааны нэршил : Борей
Га-ын норм: 0.08-0.2л/га

Хадгалах нөхцөл,хугацаа: (-5С) – (+35С) 3 жил
Хүлээх хугацаа: 28 хоног



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Имидаклоприд+лямбда-цигалотрин нь зөгийнд аюултай. Иймд зөгийн нислэгийг хязгаарлах хугацаа 120–140 цаг байна.
2. Бэлдмэлийг хэрэглэхийн өмнө анхны савалгаатайгаар сайтар сэгсрэх шаардлагатай.
3. Ажлын уусмалыг бэлтгэсэнээс хойш 4 цагийн дотор хэрэглэх шаардлагатай
4. Ажлын уусмалын усны pH 5-6,5 байх шаардлагатай
5. Инсектицидийн ажлын уусмалд адъювант нэмж болно.
6. Тебуконазол болон Пропиконазол, мөөгөнцөрийн эсрэг бодистой хамт хэрэглэж болно. Ажлын уусмалыг навчны гадаргууд жигд, чанартай бүрхэхэд тусалж, бэлдмэлийн үр нөлөөг нэмэгдүүлнэ.
7. Зааврын дагуу хэрэглэсэн тохиолдолд бэлдмэл нь таримал ургамалд хор нөлөөгүй
8. Бэлдмэлийг загасны аж ахуйн усан сангийн ариун цэврийн бүсэд хэрэглэхийг хориглоно
9. Ашигласан сав, баглааг зааврын дагуу тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй борлуулагч байгууллагад буцаан тушаах үүрэгтэй.
10. Бодисын улмаас толгой өвдөх, дотор муухайрах, арьс загатнах шинж тэмдэг илэрвэл ажиллагааг зогсоож цэвэр агаарт гарах, нүд арьсанд хүрсэн бол усаар удаан хугацаагаар угаах ёстойг анхаарна уу
11. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах
12. Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, ашигласан хувцас хэрэглэлийг зайлшгүй тусгайлан угааж цэвэрлэнэ.


ФУНГИЦИД

Таримлын өвчний эсрэг- Фунгицид

Худалдааны нэршил: Клосаль про ККР
Үйлчлэх бодис : Пропиконазол 300г/л +тебуконазол 200г/л
Аюулын зэрэг: Бага хортой

Зориулалт:
Ургамалд иш, навчаар нэвтрэн орж идэвхтэй байдлаа удаан хадгалж, эмчлэх ба урьдчилан сэргийлэх системийн үйлчилгээ үзүүлдэг фунгицид. Таримлын өсөлтийг дэмжиж идэвхжүүлдэг давуу талтай. Тебуконазол болон пропиконазол нь өөр өөр төрлийн өвчин үүсгэгчдийг дарангуйлах үйлчлэлтэй бөгөөд бие биенээ нөхдөг. Тэд ургамлын ногоон эдэд хурдан шингэж ургамлын дотор тархдаг.
Тебуконазол нь системийн үйлчлэлтэй бөгөөд урьдчилан сэргийлэх болон эмчлэх үүнд зэв өвчин, альтернариоз, фузариозын төрөлд өндөр үр дүнтэй. Ургамалд нэгээс хоёр өдрийн дотор үр дүнгээ харуулна
Пропиконазол нь мөн системийн үйлчлэлтэй урьдчилан сэргийлэх, хүчтэй эмчлэх болон устгах, патогенуудын спор үүсэлтийг дарангуйлдаг. Мөн ургалт зохицуулах нөлөөтэй бөгөөд ургамлын фотосинтезийн идэвхийг нэмэгдүүлдэг.



Хэрэглэх заавар:
Хур тунадас: 4-6 цагын зайтай байх

Зориулалт	Хэрэглэх тун / га норм	1 га-д хэрэглэх усны хэмжээ	Хэрэглэх хугацаа	Хэрэглэх арга
Буудай	Хүрэн зэв, шар зэв болон ишний зэв,түрүүний фузариоз, гуалах, гельминтоспроизын толбожилт,септориоз	0.3-0.4	200-400	Түрүүний фузориозын өвчний эсрэг цэцэглэлтийн эхэн үед, Өвчний эхний шинж тэмдэг ишний суганы доод давхаргад хонхорцог үүсч эхлэх үед шүршинэ
Арвай	Гуалалт, гельминтоспроизын толбожилт, зэв			

Хүлээх хугацаа:21-28

Хадгалах нөхцөл,хугацаа: (00С) - (+350С) 3жил



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Ажлын уусмалыг 24 цагийн дотор ашиглана.
2. Энэхүү бодис нь хүчтэй шүлтлэг эсвэл хүчтэй хүчиллэг бодисоос бусад инсектицид болон фунгицидтэй нийлэмжтэй.
3. Ургамал дээр өвчний эхний шинж тэмдэг илэрсний дараа эсвэл урьдчилсан байдлаар ашиглаж болно
4. Дараах инсектицүүдтэй мөн нийлэмжтэй (Имидаклоприд 100г/л,) гербицид (Феноксапроп-П-этил 140г/л+антидот 35г/л, Трибенурон-метил 750 г/кг) тай нийлэмжтэй
5. Сэрүүн, чийглэг цаг агаарт бодисын идэвхжил буурдаг
6. Гадаргуугийн идэвхжүүлэгч нэмж болно (трисилоксан этоксилат болон этоксилат изодецилийн спирт) ингэснээр тухайн бодисын үйлчлэлийн үр дүнг нэмэгдүүлдэг
7. Агаарын хэм: (+10°C) - (+25° C) хооронд байх
8. Ажлын уусмал бэлдэх усны pH 5-7 байна.
9. Салхины хурд: 3 м/с-ээс илүүгүй байх
10. Бодисын улмаас толгой өвдөх, дотор муухайрах, арьс загатнах шинж тэмдэг илэрвэл ажиллагааг зогсоож цэвэр агаарт гарах, нүд арьсанд хүрсэн бол усаар удаан хугацаагаар угаах ёстойг анхаарна уу
11. Уусмалыг бэлдэж байх хугацаанд тамхи татах, юм идэж уухыг хориглоно
12. Хаягдал сав үлдэгдлийг зааврын дагуу тусгайлан устгаж эсвэл тушаах шаардлагатай.
13. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах

Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, хувцсаа цэвэрлэх шаардлагатай

МЭРЭГЧ УСТГАЛЫН БОДИС

Үйлчлэх бодис: Бромадиолон 0,5%
Аюулын зэрэг: Өндөр хортой

Зориулалт:
Bromadiolone бол хоёр дахь үеийн антикоагулянт мэрэгч устгагч бодис юм. Энэ бодис витамин К мөчлөгийг дарангуйлснаар, цус бүлэгнэх чадвар багасаж, дотоод цус алдалт, цус алдаанаас үүдэн мэрэгч амьтдыг үхэлд хүргэдэг. Bromadiolone нь газар тариалан, хөдөө аж ахуй, агуулах, хадгалах газруудад хулгана, харх, тал нутгийн мэрэгчид (үлийн цагаан) устгах зорилгоор ашиглагддаг. Ихэвчлэн тодорхой барилгын агуулах гал тогоо, өрөөнд өгөөш маягаар ашиглахад тохиромжтой байдаг.



Хэрэглэх заавар:

Зориулалт	Бодисын хэмжээ (л/га)	Ажлын уусмал(л)	Хэрэглэх арга
Мэрэгч устгал	500мл	1-2л	Өгөөш бэлтгэхдээ үр будаан дээрээ (49.5кг) эхлээд бодисоо (500мл) нэмж сайтар хутгана. Үүний дараа ус зохих тунгаар нэмж хутгана.

АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ

1. Хүүхэд жирэмсэн эх мал амьтан хүрэхээргүй газар тавих шаардлагатай. Учир нь хамгийн бага тунгаар ч, хүн болон амьтанд хор болох боломжтой
2. Гол устай ойр ашиглах хориотой
3. Мэрэгчдээс гадна хөхтөн амьтдад хортой тул хэрэглэхээс өмнө анхаарна уу
4. Бодисыг шингэлэхдээ ашигласан бодисын сав суулганд өөр бодис хийхгүй зөвхөн бромадиолоныг л шингэлэхэд ашиглахыг анхаарна уу. Мөн ашигласан сав суулгыг өөр зориулалтаар ашиглах хориотой
5. Гадаа талбайд шууд цацахгүй, хаалттай саванд/наалдуулагчинд байрлуулж болно (бромадиолон хийсэн савны дээр хортой бодисын тэмдэглэгээг заавал хийх)
6. Бороотой үед мөн ашиглахыг хориглоно. Учир нь борооны усанд угаагдаж үр дүнгүй болно
7. Бромадиолоныг үр тарианд найруулсаны дараа тодорхой хугацаанд тухайн савандаа хатаах шаардлагатайг анхаарна уу
8. Бусад гербицид фунгицид инсектицид бодистой хольж ашиглах хориотой
9. Бодисын улмаас толгой өвдөх, дотор муухайрах, арьс загатнах шинж тэмдэг илэрвэл ажиллагааг зогсоож цэвэр агаарт гарах, нүд арьсанд хүрсэн бол усаар удаан хугацаагаар угаах ёстойг анхаарна уу
10. Уусмалыг бэлдэж байх хугацаанд тамхи татах, юм идэж уухыг хориглоно
11. Уусмалтай харьцахдаа заавал зузаан латекс материалтай бээлий ашиглах ёстой
12. Хаягдал сав үлдэгдлийг зааврын дагуу тусгайлан устгаж эсвэл тушаах шаардлагатай.
13. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95/N99 түвшинд) ашиглах ёстой. Учир нь энэ бодис нь хүнд маш хоруу чанартай тул бүтүү хувцас бээлий маск нэгдүгээрт байх ёстойг анхаар!

Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, хувцсаа цэвэрлэх шаардлагатай

Хүлээх хугацаа:21-28

Хадгалах нөхцөл,хугацаа: (00C) - (+350C) 3жил



ГАДАРГУУГИЙН ИДЭВХЖҮҮЛЭГЧ

БОДИСЫН ҮЙЛЧЛЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ГАДАРГУУГИЙН ИДЭВХТ БОДИС

Үйлчлэх бодис: Трисилоксан этоксилат
Аюулын зэрэг: Бага хортой

Зориулалт:
Пестицидийн нэвчилт, үр нөлөөг 20-50% хүртэл нэмэгдүүлдэг. Хөөсрөлт үүсдэггүй давуу талтай. Навчны гадна давхаргын нэвтрэх чадварыг сайжруулдаг . Пестицид болон уриншийн бодис, навчны бордоотой хамт хэрэглэхэд навчин дээр буух ажлын уусмалын шингэлт, нэвчилтийг сайжруулснаар бодис болон бордооны ашиглалтыг нэмэгдүүлдэг. Силикон суурьтай гадаргуугийн идэвхт бодис нь олон давуу талтай үүнээс дурдвал: Хог ургамалд уриншийн бодисын үйлчлэлийг сайжруулна. Ажлын уусмал навчны гадаргууд бүрэн, жигд тархаж бодисын үр нөлөөг дээшлүүлдэг.



Хэрэглэх заавар:

Зориулалт	Хэрэглэх тун, норм (л)	Ажлийн уусмал(л)	Хэрэглэх арга, хугацаа
Бүх төрлийн тарималд навчны бордоо, уриншийн бодисын үйлчлэл нэмэгдүүлэх	1	3000	Ажлын уусмалыг бэлтгэхдээ шүршигчийн савны 80%-д усаа дүүргэж гадаргуугийн идэвхжүүлэгчээ нэмж хийн сайтар хутгана. Бэлэн болсон ажлын уусмал дээрээ пестицид болон бордоогоо нэмнэ. /1 литр гадаргүүгийн идэвхжүүлэгчийн ажлын уусмал 3000л байх ба пестицидийн ажлын уусмал 200л/га байх үед 15га-ын зарцуулалт байна/

Худалдааны нэршил: Смарт вэт

Хадгалах нөхцөл, хугацаа:(00С)– (+200С)-т 2 жил



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Ажлын уусмалыг 24 цагийн дотор ашиглана.
2. Трисилоксан этоксилатыг хэрэглэх үед хор цацагчийн бункер дах өмнөх бодисын үлдэгдэл дараагийн тарималд хүчтэй үйлчлэх боломжтой тул танкийг сайтар цэвэрлэх шаардлагатай.
3. Лямбда-цигалотрин, Имидаклоприд, Тиометоксам, зэрэг инсектицидтэй нийлэмжтэй.
4. Хэт хүчтэй шүлтлэг уусмал pH>10 тай хольж болохгүй мөн зэсийн өндөр агууламжтай пестицидтэй нийлэмжгүй
5. Ихэнх системийн болон контакт фунгицидтай нийцтэй жишээ нь: Тебуконазол, Пропиконазол, Дифеноконазол гэх мэт
6. Глифосат, 2,4Д амин, Дикамба, Клопиралид, трибенурон, Феноксапроп Хизалофоп зэрэг гербицидүүдэд хамгийн тохиромжтой.
7. Салхины хурд: 3 м/с-ээс илүүгүй байх
8. Агаарын хэм: ($+10^0$) - ($+25^0$) хооронд байх
9. Бодисыг идэх, уух болон бодистой харьцаж ажиллаж байх үед тамхи татах ил гал гаргахыг хориглоно.
10. Трисилоксан этоксилат нь хүнд хоруу шинж чанартай тул болгоомжтой хандана уу
11. Бодисын улмаас толгой өвдөх, дотор муухайрах, арьс загатнах шинж тэмдэг илэрвэл ажиллагааг зогсоож цэвэр агаарт гарах, нүд арьсанд хүрсэн бол усаар удаан хугацаагаар угаах ёстойг анхаарна уу
12. Хаягдал сав үлдэгдлийг зааврын дагуу тусгайлан устгаж эсвэл тушаах шаардлагатай.
13 .PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах

Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, хувцсаа цэвэрлэх шаардлагатай

ГЕРБИЦИДИЙН ИДЭВХЖҮҮЛЭГЧ БОДИС

Үйлчлэх бодис: Этоксилат изодецилийн спирт 900г/л
Аюулын зэрэг: Бага хортой

Зориулалт:
Этоксилат изодецилийн спирт нь ионгүй гадаргуугийн идэвхт бодис (non-ionic surfactant) бөгөөд гербицид эсвэл бусад пестицидтэй хамт хэрэглэгддэг. Энэ нь гербицидын ажлын уусмалыг навчинд тогтоож, гадаргуун дээр тархах гербицидын уусмалаар навчны гадаргууг бүрэх нийт талбай нэмэгдүүлнэ. Пестицидийн үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор хамт хэрэглэгддэг. Навчны гадаргуу үсэрхэг эсвэл лавын өнгөрөөр бүрхэгддэг навчтай хог ургамлын төрлүүдийг /гагадай, морин шарилж, мэхээр, сүүт өвс/, шигүү навчтай хог ургамлын төрлүүдийг /азаргана, улбар аргуй, тайжийн жинс, ганд бадраа/ үр дүнтэй устгана. Гербицидын ажлын уусмалд Этоксилат изодецилийн спирт бодисыг нэмэхэд гербицидын уусмал нь бороонд тэсвэртэй болдог. Адъювант (гадаргуун-идэвхит бодис) гербицидтай хамт хэрэглэнэ, ингэснээр тэдгээрийн үр ашгийг 2 дахин нэмэгдүүлнэ.






Хэрэглэх заавар:

Бэлдмэлийн тун	Ажлын уусмал
0.2 л/га	200л/га

Худалдааны нэршил: Адью

Хадгалах хугацаа, нөхцөл: 4 жил, -10°C-аас +35°C



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ

1. ВДГ, ВРК, ВРГ хэлбэртэй гербицидүүдтэй хамт хэрэглэж бодисын үйлчлэлийг сайжруулж болно.
2. Адьюг үет ургамлын эсрэг бодисуудтай хамт хэрэглэхийг зөвлөдөггүй.
3. Их хэмжээний хөөс үүсгэдэг тул хор цацагчийн бункерт хамгийн сүүлд нэмж хийхийг зөвлөдөг.
4. Ажлын уусмалын усны pH 5.5-7 байх шаардлагатай
5. Бэлдмэлийг шүршигч саванд дараах дарааллаар холино. Гадаргуугийн идэвхтэй бодисын биологийн үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд СП (водорастворимые пакеты) → СП → ВДГ (СТС) → СК (ВСК) → СЭ → КНЭ (КМЭ, МЭ, КЭ, ЭМВ) → ВРГ → ВРК (ВР) → ПАВ хэлбэрийн гербицидтэй хамт хэрэглэж болно.
6. Трибенурон-метил флорасулам(бомба), Метсульфурон-метил (магнум), Трибенурон-метил (Мортира), Клопиралид, глифосат, флорасулам, 2,4Д-тай нийцэмжтэй.
7. Бодисын найрлагандаа антидот агуулсан бүтээгдэхүүнд Этоксилат изодецилийн спирт нэмж хийх нь антидотын үйлчлэлийг сулруулдаг тул нэмж хийхийг зөвлөдөггүй
8. Бодисын улмаас толгой өвдөх, дотор муухайрах, арьс загатнах шинж тэмдэг илэрвэл ажиллагааг зогсоож цэвэр агаарт гарах, нүд арьсанд хүрсэн бол усаар удаан хугацаагаар угаах ёстойг анхаарна уу
9. Уусмалыг бэлдэж байх хугацаанд тамхи татах, юм идэж уухыг хориглоно
10. Хаягдал сав үлдэгдлийг зааврын дагуу тусгайлан устгаж эсвэл тушаах шаардлагатай.
11. PVC бээлий, нүүрний хаалт, респиратор (N95 түвшинд) ашиглах

Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, хувцсаа цэвэрлэх шаардлагатай



ӨСӨЛТ ДЭМЖИГЧ, ЗОХИЦУУЛАГЧ БИО БҮТЭЭГДЭХҮҮН, БОРДОО

Өсөлт зохицуулагч / амин хүчлийн бордоо

Үйлчлэгч бодис: Amino acid+ Epi brassinolide + Active Peptide Enzyme+Zn,Na

Ургамалд үзүүлэх нөлөө, ач холбогдол:

- Абиотик нөлөө буюу ган, хэт халалт, хуурайшилт, цочир хүйтрэлт, хяруу, мөндөр гэх мэт орчны таагүй нөхцөлөөс таримал ургамалд үзүүлж буй стрессээс урьдчилан сэргийлэх, стресс тайлах ач холбогдолтой. Ургамалд ус хадгалах, амьдрах чадварыг нь нэмэгдүүлж хамгаалах үүрэгтэй. Үндэс орчмын хөрсний чийгийг хадгалж барьдаг.
- Биотик нөлөө буюу Шавжны гэмтэл, өвчин үүсгэгчийг эсэргүүцэх, нөхөн төлжүүлэх ач холбогдолтой. Ургамлын өсөлтийг тэтгэж, шим тэжээлийг нэмэгдүүлэх олон төрлийн амин хүчил болон бичил элемент агуулсан учир ургамлын фотосинтезийн процессыг идэвхжүүлж, уургийн нийлэгжилтийг нэмэгдүүлж, үндсийг идэвхжүүлнэ.
- Навчны бордоотой хамт хэрэглэхэд, ургамлын стрессийн тэсвэр, шим бодисын шингээлт, зөөвөрлөлтийг дэмждэг бордоог ургамалд ашиглагдах хэлбэрт оруулдаг, эсийн түвшинд биологийн идэвхт үзүүлэх ач холбогдолтой.
- Ургамлын цэцэглэлтийг дэмжиж, үр жимсний хэмжээ болон чанарыг 20-25% нэмэгдүүлдэг.
- Нэгж га талбайгаас авах ургац нэмэгдүүлдэг.



Ургалтын үеийн бордоог хэрэглэх шалтгаан:

- Цаг агаарын таагүй үзэгдлүүд, тогтворгүй байдал нь (гангын давтамж,гэнэтийн аадар,мөндөр, цочир хүйтрэлт, хэт халалт) таримал ургамлыг стресст оруулдаг. Энэ нь таримлын ургалтын үе шатыг богиносгох, 1000 үрийн жинг багасгах, ургацыг бууруулах нэг шалтгаан болдог. Тиймээс таримлын гадаад орчны нөлөөнд өртөх эрсдэлийг бууруулах, ургацаа хамгаалах нэг шийдэлд био гаралтай өсөлт зохицуулагчийг хэрэглэх явдал юм.

Хэрэглэх заавар:

Зориулалт	Хэрэглэх тун / га норм	1 га-д хэрэглэх усны хэмжээ	Хэрэглэх хугацаа	Хэрэглэх арга
Бүх төрлийн таримал ургамал	0.4-0.5 л/га	200л-400л/га	Ургалтын бүх үе шатанд	Доройтсон ургамлыг сэргээх, бордооны үйлчлэлийг нэмэгдүүлэх зорилгоор дангаар болон бордоотой хамт хэрэглэнэ.




АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Агаарын хэм +26°C-аас дээш үед эсвэл бороо, салхи шуургатай үед хэрэглэхээс зайлсхийх
2. Найруулж бэлэн болсон уусмалыг 24 цагийн дотор хэрэглэнэ.
3. Нарны шууд тусгалаас хол хуурай сэрүүн газар хадгална.
4. Бусад төрлийн бордоо болон пестицидтэй хамт хэрэглэхийн өмнө нийлэмжтэй байдлыг үзэх (ээдэх, тунадас үүсэх тохиолдолд хамт хэрэглэхийг хориглоно.)
5. Шүлтлэг орчинд мэдрэмтгий тул энэ төрлийн пестицид болон ЕС эмульсийн суурьтай бүтээгдэхүүнтэй хамт хэрэглэхгүй. Тунадас үүсэх, ээдэх гэх мэт нийлэмжгүй байдал нь ургамалд сөрөг нөлөөтэй
6. Хүхэр агуулсан бүтээгдэхүүнтэй хэрэглэх үед, 2 дахин их усаар шингэлэх шаардлагаттай

Ургамлын гаралтай өсөлт зохицуулагч

Үйлчлэгч бодис: Эпи-брассинолид 0,01% SL



Таримал ургамлын стрессийг даван туулахад BR24 тусална.
- Ургамлыг стресст оруулах хэт халалт, ган, хүйтрэлт, хөрсний давсжилт зэрэг орчны таагүй нөхцөлийг тэсвэрлэхэд BR24 нь эсийн түвшинд хүртэл үйлчилж хамгаалдаг.
- Таримлын ургалтын үед навчны бордоотой хамт хэрэглэхэд бордооны үйлчлэл, ургамлын бордооны ашиглалтыг нэмэгдүүлдэг
- Пестицидийн дараах стресс тайлдаг.
- Үндэсний хөгжлийг дэмжин хүчирхэг үндэсний системийг бий болгодог.
- Рапс болон тоонолжин цэцэгтийн овгийн тарималд гойд сайн нөлөө үзүүлдэг.

Хэрэглэх заавар:
Агаарын хэм: (+10 С) - (+25 С)
Салхины хурд: 3 м/с-ээс илүүгүй байх
Хур тунадас: 3 цагын зайтай байх

Таримлын ургалтын үед бордоо болон пестицидтэй хамт зөвлөсөн тун хэмжээгээр 2-3 удаа хэрэглэж болно.

Таримал	Хэрэглэх тун (л/га)	Ажлын уусмал (л/га)
Улаанбуудай Арвай Овъёос Рапс Эрдэнэшиш Вандуй	200	200

АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Илүү тунгаар ашиглах нь илүү ашигтай гэсэн үг бус илүү зардал мөн ургацын эрсдэлийг нэмнэ иймд тунг хэтрүүлэн хэрэглэх нь ургамлын физиологт сөрөг нөлөөтэй тул заавар зөвлөмжийн дагуу ашиглана уу!

Худалдааны нэршил: BR24

Хадгалах хугацаа: 2 жил

Навчаар үйлчлэх тэнцвэрт агууламжтай бордоо

$N+P_2O_5 + K_2O$
(20-20-20) +TE

Зориулалт:
Үр тариа, улаанбуудай, тосны таримал, рапс гэм мэт бүх төрлийн тарималд ургалтын үед навчаар үйлчилж цогц тэжээл өгч, таримлын чанар болон ургацыг нэмэгдүүлдэг. Азот, фосфор, калийн өндөр агууламжтай, усанд бүрэн уусдаг нийлмэл бордоо нь ургалтын эхэн үеэс л таримлыг шим тэжээлээр хангах, ногоон массыг нэмэгдүүлэх, үндэсний хөгжлийг дэмжих, ургалтын эрчим нэмэгдүүлэх үр нөлөөтэй. Макро элемент болох Азот, Фосфор, Калийн тэнцвэрт агууламж нь ургамлын өсөлт хөгжлийг жигд дэмжиж болц гүйцэх хугацааг түргэсгэж ургацын чанар нэмэгдүүлдэг. Таримал ургамлын ургалтын эхэн үеэс дунд үе хүртэл үндэсний системийн хөгжил, ногоон масс нэмэгдүүлэх зорилгоор өсөлт зохицуулагчтай хамт хэрэглэнэ. Ургамлын идэвхтэй өсөлтийн үед хэрэглэвэл илүү үр дүн сайтай.



Хэрэглэх заавар:

Таримал	(20-20-20)+TE	Ажлын уусмал (л/га)	Хэрэглэх хугацаа
Улаанбуудай Арвай, Овъёос	0.3-0.4+BR24 0.4(л/га)	200	Бутлалтын үед
Рапс			Жинхэнэ 3-4 навчтай үеэс
Ногоон тэжээл			Ургалтын бүх үе шатанд

Өсөлт зохицуулагч болон А мин хүчлийн бордоотой хамт хэрэглэхэд ургамлыг богино хугацаанд сэргээж, таримал ургамлын абиотик болон биотик стресс тайлдаг.


Ургалтын үеийн бордоо

Калийн агууламж өндөртэй бордоо - K хүч

NPK (13-7-40) +TE

Агууламж:

Азот:13%	Зэс: 0.01%
Фосфор:7%	Төмөр:0.02%
Кали:40%	Цайр:0.02%
Магни:0.06%	Манган:0.02%
Молибден:0.06%	Хүхэр:3.5%
Бор: 0.06%	



K хүч нь калийн өндөр агууламжтай, усанд бүрэн уусдаг, таримлын ургалтын үед навчаар үйлчилдэг өндөр үр ашигтай , ургацыг мэдэгдэхүйц нэмэгдүүлдэг нийлмэл бордоо юм.

- Хүрээлэн буй орчинд ээлтэй
- Ургамал хамгаалах бодис болон бусад төрлийн бордоотой нийлэмжтэй
- Бүрэн хэмжээний түрүү үүсэлтийг дэмжинэ
- Гербицидээс үүсэх стрессийг бууруулна
- Таримлын чийгийн нийт алдагдал бууруулна
- Рапсын хувьд баг цэцэг үүсч, үр сайн бүрэлдэнэ
- Үрийн цутгалт болон жин, массыг нэмэгдүүлнэ
- Үр боловсрох хугацааг түргэсгэнэ.
- Тосны таримлын үрийн ургац дээшлүүлэхээс гадна тосны гарцыг нэмэгдүүлдэг.

Таримал	K хүч Га/норм (кг/га)	BR-24 Га/норм (кг/га)	Amino BR	Ажлын уусмал (л/га)	Хэрэглэх хугацаа
Улаанбуудай	0.3-0.4	0.2-0.3	0.3-0.4	200	Туг навч үүсэх үеэс гол хатгаж түрүү үүсэх үед навчаар 2удаа
Арвай	0.3-0.4	0.2-0.3	0.3-0.4		
Овъёос	0.3-0.4	0.2-0.3	0.3-0.4		
Рапс	0.3-0.4	0.2-0.3	0.3-0.4		Ургалтын бүх үе шатанд



АНХААРАХ ЗҮЙЛ БОЛОН ЗӨВЛӨМЖ !

1. Таримлын ургалтын хугацаанд нийт 2-3 удаа 7-14 хоногийн давтамжтай хэрэглэхийг зөвлөдөг.
2. K хүч + BR-24
3. K хүч+Amino BR
4. Таримал ургамалд кали дутагдахад:

Ургамал калийн дутагдал орсноор ургамлын газрын дээд эрхтэн, үндэсний өсөлт, хүйтэн болон налалтанд тэсвэрлэх чадвар буурч үрийн ургац буурдаг

5. Ашиглах бордооны төрлийг хөрсний шинжилгээн дээр тулгуурлан тухайн газарт аль шим тэжээл дутагдаж байгаагаас хамааран бордоог сонгох нь маш чухал
6. Калийг хэтрүүлбэл Магни, Кальци шимэгдэлт багасч болдог. Иймд эрдэсийн тэнцвэртэй байдал чухал гэдгийг анхаарна уу

Ажил дууссаны дараа гараа савандаж угаах, хувцсаа цэвэрлэх шаардлагатай

Пестицид болон бордоог шүршигчийн саванд хийх зохимжтой дараалал

01 Усны pH бууруулагч /шингэн/

02 Гадаргуугийн идэвхжүүлэгч /шингэн/

03 Усанд уусдаг бордоонууд

04 Усанд уусдаг уут бүхий хуурай бэлдмэл /СП/

05 Уутгүй хуурай бэлдмэлүүд /эхлээд нунтаг СП дараа нь ВДГ, СТС, эх уусмал бэлтгэн найруулах шаардлагатай/

06 Суспенз хэлбэрийн шингэн бэлдмэлүүд /СК, КС, ВСК/

07 Суспенз эмульс /СЭ/

08 Эмульсэн бэлдмэлүүд /КНЭ, КМЭ, МЭ, ЭМВ, МХЭ/

09 Усанд уусдаг хуурай үрлэн бэлдмэлүүд /ВРГ/

10 Усанд уусдаг шингэн бэлдмэлүүд /ВР, ВРК, ВГР/

11 Адьювант /гадаргуугийн идэвхжүүлэгч бодис-ПАВ/

BR24

Эпи-брассинолид 0,01%



+ Үндэсний хөгжлийг дэмжинэ

+ Үр тарианд бутлалтын явцыг идэвхжүүлнэ

+ Бүрэн хэмжээний түрүү үүсэлтийг дэмжинэ

+ Үрийн цутгалт болон жин массыг нэмэгдүүлнэ

+ Таримлын хүйтэнд болон ганд, өвчин хортонд тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлнэ



ТАРИМАЛ УРГАМАЛ



Ургах Бүхнийг URGA.MN-с

САЛБАР-1
БЗД, 3-Р ХОРОО, АРСЛАНТАЙ ГҮҮР,
ХХААЯамны ХОЙНО, 20/2-Р БАЙР
7272-0808

САЛБАР-2 / ТӨВ
БЗД, 1-Р ХОРОО, ЗАЛУУЧУУДЫН ӨРГӨН
ЧӨЛӨӨ-21, САНСАРЫН И-МАРТЫН
ЗАМЫН ХОЙНО НОРТ ЦЕНТР 109 ТООТ
7272-0808
6690-9090

САЛБАР-3 / УХБодисын агуулах
СХД, 32-Р ХОРОО 384 ГАРАМ,
29 ГУДАМЖ 62А ТООТ
9997-9628
6690-9090

Ургамал хамгааллын зөвлөх мэргэжилтнүүд:
6012-1212
6014-1414
8894-0052

Таримал Ургамал ХХК

tarimalurgamal2016@gmail.com
tarimalurgamal2016@urga.mn